




2005 оноос эрхлэн гаргав.

ЦДҮС ТӨХК-ИЙН ХЭВЛЭЛ
www.transco.mn

ДАМЖУУЛАХ

Сүлжээ



№04 (157) 2023 оны 10 сар

220/110/35 кВ БАГАНУУР ДЭД СТАНЦЫН 220 кВ-ЫН ИХБ- ИЙН ӨРГӨТГӨЛИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭВ

ЦДҮС ТӨХК-ийн Зүүн-Өмнөд Бүсийн салбарын 2023 оны төлөвлөгөөт ТЗБАХ-ний ажлын хүрээнд 220/110/35 кВ Багануур дэд станцын 220 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн барилга угсралт ажлыг 08 дугаар сарын 26-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрийн хооронд засварын албаны

дарга Г.Болдхуяг, РХАХТА-ны ахлах бөгөөд НРХА-ын инженер Б.Мягмарсүрэн нараар ахлуулсан ЗӨБС-ын 35 ажилтан, Улаанбаатар салбарын 13 ажилтан, ТҮМХ-ийн 2 ажилтан, нийт 10 машин механизмтай бригадууд ажлыг графикт хугацаанд хийж гүйцэтгэн схемийн найдвартай ажиллагааг хангав.



НҮҮР-3

Б.ЭРХЭМЗАЯА:
ИНЭЭДТЭЙ Ч ЮМ ШИГ,
ГОМДМООР Ч ЮМ ШИГ
ТӨСӨВТЭЙ АЖИЛЛАЖ
БАЙНА

НҮҮР-5

ТӨВИЙН БҮСИЙН
САЛБАР

НҮҮР-7


ЗҮҮН-ӨМНӨД
БҮСИЙН САЛБАР

НҮҮР-9

ТӨВ УДИРДЛАГА

НҮҮР-11

“ОЛОН УЛСЫН
АХМАДЫН ӨДӨР”-ИЙГ
ТЭМДЭГЛЭВ



БАГАНУУР – БӨӨРӨЛЖҮҮТИЙН 220 КВ-ЫН 261, 262-Р ЦДАШ-ЫН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫГ ДУУСГАЛАА



"ЦДҮС" ТӨХК болон "Цэцэнс майнинг энд энерги" ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу Багануур – Бөөрөлжүүт 220 кВ-ын 261, 262-р цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/-ын нэгдүгээр багцын барилга угсралтын ажлыг хийж дуусгалаа. Нийт таван салбарын 100 гаруй хүн, 15 машин, техник хэрэгсэлтэйгээр 2023 оны 5-р сарын 08-ны өдрөөс 10-р сарын 21-ний хооронд амжилттай хийж гүйцэтгэлээ.

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 10-р сарын 17-ны өдрийн тушаалын дагуу техникийн комиссын шийдвэрээр Багануур-Бөөрөлжүүт

220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын №1-33-р тулгуурыг 209, 210-р агаарын шугамын №279-р тулгуурт шилжүүлж, холбон хүчдэлд амжилттай залгав.


Багануур – Бөөрөлжүүтийн 220 кВ-ын 261, 262-р ЦДАШ-ын нэгдүгээр багцын 15,65 км трассын урттай хос хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажлыг төлөвлөгөөт хугацаанд аюул осолгүй, амжилттай гүйцэтгэхэд гар бие оролцсон бүх инженер техникийн ажилчдадаа талархал илэрхийлж, ажлын амжилт хүсье!



"ШИНЭ НАЛАЙХ" ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНД МОД ТАРИВ

Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" хөдөлгөөний хүрээнд "Намрын мод тарих өдөр" 2023 оны 10 дугаар сарын 04-нөөс 10 дугаар сарын 16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ийн "Улаанбаатар" салбарын ажилтнууд тус өдөрлөгийн хүрээнд Монгол Улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Ойн газар"-ын гаргасан төлөвлөгөө, хуваарийн дагуу Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэнд 1 ширхэг гацуур, 5 ширхэг хус модыг тарьсан.





Б.ЭРХЭМЗАЯА: ИНЭЭДТЭЙ Ч ЮМ ШИГ, ГОМДМООР Ч ЮМ ШИГ ТӨСӨВТЭЙ АЖИЛЛАЖ БАЙНА



Монгол Улсын өргөн уудам газар нутгийг хэрсэн цахилгааны шугам сүлжээ олон жилийн насжилттай болсон. Солих шаардлагатай тоног төхөөрөмж маш их бий. Гэвч хойд хормойгоо авч урд хормойгоо нөхөх маягтай олон жилийг ардаа орхисноос мөн цаг уурын хүчин зүйлээс шалтгаалж энэ жил цахилгаан дамжуулах шугамд хэд, хэдэн томоохон аваар гарсан билээ. Нөхцөл байдал ямар байгаа талаар “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Ерөнхий инженер Б.Эрхэмзаяатай ярилцлаа.

-Олон жил иргэдэд цахилгаан эрчим хүч дамжуулсаар ирсэн компанийнхаа үйл ажиллагааны талаар манай уншигчдад товч танилцуулна уу?

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” компани Монгол Улсын нутаг дэвсгэрийн 66 хувь, хүн амын 72 хувийг хамарсан 5360 км цахилгаан дамжуулах агаарын шугамыг хариуцан ажилладаг. Тодруулбал, 220 кВ-ын 2024 км, 110 кВ-ын 3311,6 км, 35 кВ-ын 23,7 км цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбогдсон нийт 82 дэд станцын үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай байдлыг хангаж ажиллаж байна. Нийт 1283 инженер, техникийн ажилтан Улаанбаатар, Төв, Хангай, Зүүн Өмнөд, Говийн гэсэн таван салбарын бүтцээр ажилладаг.

-Цахилгаан дамжуулах шугамуудын ашиглалтын хугацаа ямар байдалтай байгаа вэ.

Засвар шинэчлэлтийн ажил хийгдэж байна уу?

-35-220 кВ-ын хүчдэлийн түвшинд төмөр болон төмөр бетон тулгуурууд ашиглаж байна. Эдгээрээс төмөр тулгуур нь 50 жилээс дээш, төмөр бетон тулгуур нь 35 жилээс дээш ажиллах үйлдвэрийн заавартай. 110 кВ-ын агаарын шугамууд 1963 оноос ашиглалтад орсон. Төвийн бүсийн салбарт харьяалагдах Шарын гол-Дарханы хаалттай хуваарилах байгууламж, мөн 220 кВ-ын агаарын шугамууд 1976 оноос ОХУ-ын системтэй зэрэгцээ

ажилладаг 257, 258-р тооцож болно. Нийт цахилгаан дамжуулах сүлжээний 70 гаруй хувийнх нь ашиглалтын хугацаа хэтэрсэн.

-Хуучирч, ашиглалтын хугацаа дууссан тоноглолуудыг хэрхэн ажиллуулж байна вэ?

-Ашиглалтын хугацаа нь дууссан тоноглолуудын ашиглалтыг цаашид хэрхэн авч явах талаар ямар нэгэн зааварчилгаа, дүрэм одоогоор байхгүй. Олон жилийн үечилсэн графикын дагуу үзлэгээр илэрсэн гэмтлийг устгах, хэсэгчлэн сольж шинэчлэх ажлыг л хийдэг. Үзлэгээр габарит барихгүй хазайсан, гаднын биет, тусгаарлагч элемент нэвт цохигдсон, утасны судал тасарсан, чичиргээ намдаагч гүйсэн, тулгуурын боолтон холбоос суларсан, төмөр бетон тулгуурт босоо, хөндлөн цууралт үүссэн зэрэг маш олон гэмтлийг илрүүлж яаралтай засварлан ажиллаж байна. Манай компанийн түүхэнд гарч байгаагүй гэмтэл гарсан

-Энэ жил цахилгаан дамжуулах шугамын дагуу томоохон аваарууд гарлаа. Эдгээр аваар юунаас болж гарав, хэрхэн засварлаж хэвийн ажиллагаанд оруулсан бэ?

-Сүүлийн үед хамгийн их хүндрэл үүсгэж байгаа хүчин зүйл бол цаг уурын өөрчлөлт. Цаг агаараас болж энэ жил томоохон хэмжээний дөрвөн саатал, аваар гарсан. Өнгөрсөн нэгдүгээр сард 220 кВ-ын 203, 204 дүгээр агаарын шугамын тулгуур унасан бол гуравдугаар сард 215, 216 дугаар агаарын шугамын тулгуур, зургаадугаар сард 110 кВ-ын Хархорин А, Б (үндсэн болон

нөөцийн хоёр хэлхээт) агаарын шугамын 24 ширхэг тулгуур Булган аймгийн Гурван булаг сумын нутагт унасан. Наймдугаар сард Хархорин А, Б агаарын шугамын таван ширхэг тулгуур Архангай аймгийн Хашаат сумын нутагт унасан. Үүссэн нөхцөл байдлыг манай инженер, техникийн ажилтнуудын ур чадвараар богино хугацаанд зассан ч цаашид аваар давтагдахгүй байх талаас нь судалгаа хийж эхэлсэн. Булган-Өвөрхангай аймгийг холбодог 110 кВ-ын Хархорин А,Б агаарын шугам есөн

аймгийн 70 гаруй сумыг цахилгаан эрчим хүчээр хангадаг. Тус шугамд 24 ширхэг тулгуур унасан нь манай компанийн түүхэнд гарч байгаагүй гэмтэл юм. Агаарын шугам утсаар хоорондоо холбоотой байдаг. Нэг тулгуур унавал нөгөөхөө татаж унагадаг аюултай. Төгсгөлийн эргэлтийн төмөр анкераас анкерын хооронд тулгуур унасан гэсэн үг. Унасан тулгууруудыг буцаагаад ашиглах ямар ч боломжгүй болсон. Бид нөөцөд байсан бүх тоноглолоо ашиглаж засварласан. Цаашид бид алгаслалт, хөрсний гулсалт ихтэй газруудад шугамыг хүчитгэн анкер босгох болон төмөр бетоны гадуур нь бетон болон төмөр хийцээр бөгжлөх, өлгийдөн хүчитгэх ажлуудыг хийж байна. Үүний цаана хөрөнгө мөнгө яригдана. Дамжуулах компани улсаас батлагдсан төсөв, зардлаараа л ажилладаг. Гэнэтийн аваар гарсан тохиолдолд хөрөнгө мөнгө тулгамдсан асуудал болдог. **-Хуучирч гэмтсэн шугам болон бусад төхөөрөмжөө хэрхэн засварладаг вэ. Хөрөнгөмөнгөний асуудал тулгамддаг гэж байна. Тухайлбал, өнөөдрийн байдлаар хаана техникийн засвар хийх, шинэчлэх шаардлагатай байгаа вэ?**

-Энэ жил Эрчим хүчний яамнаас трассын дагуу шалгалт үзлэг хийх үүрэг даалгавар өгсөн. Хугацаатай учир өөрсдийн хөрөнгөөр хийх боломжтойг нь хийж, ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдах ажлыг үе шаттай хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Бид дээр дурдсан шиг олон жилийн графикт засвар үйлчилгээг хийхээс гадна ээлжит болон ээлжит бүс үзлэгээр илэрсэн гэмтлийг устгах ажлуудыг хийдэг. Бидэнд тулгамдаж байгаа бас нэг асуудал бол дамжуулагч утасны хуучралт. Тус утас нь ган голтой хөнгөн цагаан утас байдаг. Хөнгөн цагааны гадна тал бохирдож, улмаар дотогш гол руугаа нэвчээд дунд нь бэхлэх гангуудыг зөв идэх, утсууд нь тасарч унах, унахдаа тулгууруудыг татаж унах гэмтэл гарч байсан. Чойр-Бор-Өндөрийн цахилгаан дамжуулах шугамын дамжуулагчийг лабораторид өгөхөд шаардлага хангахгүй гэдэг дүгнэлт гарсан. Үүнийг солихын тулд 20 гаруй тэрбум төгрөгийн асуудал яригдана. Монгол Улсыг хэрсэн цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг бүгдийг нь нэг дор сольё гэвэл улс орны хөрөнгө мөнгөнд хэрхэн тусаж билээ. 100 жилийн дотор босгосон том бүтээн байгуулалт шүү дээ. Улс орны өөрийнх нь онцлог байна. Манайх эрчим хүчийг дамжуулахын тулд үүсгэвэр болон хэрэглэгчийн хооронд урт шугамууд татсан. Маш алслагдмал байдаг. Улаанбаатар хотод үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч хаа байсан Баянхонгор, Завханд хүрч байна. Гэхдээ Завхан аймгийн зөвхөн ахуйн хэрэглээг л хангаж, томоохон хэмжээний үйлдвэр, уурхайн эрчим хүчийг хангаж чадахгүй. Хэрвээ алслагдсан аймгийн том уурхай, үйлдвэрүүдийг эрчим хүчээр хангаж чаддаг бол цахилгаан эрчим хүч дамжуулсныхаа төлөө хөрөнгө оруулалт авдаг тогтолцоо байх хэрэгтэй л дээ. Ингэвэл эргүүлээд өртгөө нөхөөд явах боломжтой болно. Тиймээс эдийн засгийн үр өгөөж талаасаа сольж шинэчлэх л ёстой. Гэтэл эрчим хүчний салбар алдагдлаа нөхөж чадахгүй байгаа. Өр багасах биш үргэлж нэмэгдэж байна. Тиймээс техникийн шинэчлэлд оруулах хөрөнгө алга. Монгол Улс эрчим хүчний сул системтэй.

-Дэлхийд манайх шиг алслагдмал газар руу урт татсан агаарын шугамтай орон цөөхөн гэдэг. Хэрэв ямар нэгэн гэмтэл гарвал зардал ихтэй, хүрэх газар нь хол юм, тийм үү?

-Монгол Улс эрчим хүчний сул системтэй. Үүсгэврээс хэрэглэгчид очихдоо хоёр хэлхээгээр очно. Хэрэв энэ хоёр хэлхээ унавал аюултай. ОХУ, Монгол хоёр ижилхэн сул системтэй. Барууны орнууд газар нутаг багатай. Дээрээс нь хэрэглэгч, хүн ам нягтаршил ихтэй учраас хэрэглэгч, үүсгэвэр хоёрын хооронд 3-4 шугамаар зэрэгцээ ажиллагаанд холбогчихдог. Нэг шугам нь гэмтэхэд нөгөө гурав нь аваад явчихдаг учраас их найдвартай байдаг. Манайх газар зүйн тархмал байдлаасаа шалтгаалж сул систем гэж нэрлэгддэг. Эрчим хүчний салбар үүсгэврийн томоохон дутагдалтай. Сүүлийн 40

жилд томоохон үүсгэвэр баригдсангүй. 2024 онд ашиглалтад орох 150 мегаваттын Бөөрөлжүүтийн дулааны цахилгаан станцыг хүлээж байна. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэж байгаа эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуур ашиглалтад орчихвол 2023-2024 оны өвлийн их ачаалалд их нэмэр болох учиртай. Хэрвээ бид үнэ тарифаа зөв зохицуулж, эрчим хүчний зөв зохистой хэрэглээг бий болгож чадвал тодорхой хэмжээнд тохируулах боломж байдаг. Өглөө, оройн оргил цагт ямар нэгэн байдлаар балансжуулах, томоохон хэрэглэгчдээ арай өөр цагт ажиллуулах, ажиллах цагийн горимыг нь өөрчлөх зохицуулалтыг хийж болно.

-“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-д улсаас жилд хэчнээн төгрөг төсөвлөдөг вэ? Төсөвлөсөн хөрөнгө нь үйл ажиллагааны зардалд хүрэлцдэг үү?

-Урсгал болон их засварын ажилд 10 орчим тэрбум төгрөг төсөвлөдөг. Үүсгэвэр нь хязгаартай учраас ирүүлж байгаа саналуудын 60-70 хувийг хасаж, дотор нь эрэмбэлж, хөрөнгө мөнгөндөө багтааж тухайн жилдээ батлагдсан ажлуудыг 100 хувь хийж өвлийг давдаг. Манай инженер, техникийн ажилчдаас “110 кВ-ын цахилгааны шугамын урсгал засварт 200 төгрөг хуваарилсан байна” гэдэг гомдол санал ирдэг. Инээдтэй ч юм шиг, гомдмоор ч юм шиг байгаа биз. Тоосжилт ихтэй цахилгааны шугамыг арчих материал авах гэхээр 200 төгрөг нь хүрдэггүй. Хөөрхий монте́рууд маань бээлий, хувцсаараа арчдаг. Гэхдээ алхам алхмаар өөрчлөгдөж байгаа зүйл ч бий. Бид өөрсдийн нөөц бололцоогоор мэдээллийн хяналтын системтэй болж байгаа. Ингэснээр 12 станцыг алсаас хянах боломжтой болох юм. Гадаадын донор орнууд болон дотоодын эх үүсвэр, хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмжөө сольж байна. 220 кВ-ын хүчдэлийн түвшингийн хэмжүүрийн трансформатор, таслуурдууд солигдсон. Хуучны тосон таслуурыг хийн таслуураар солих ажил дуусаж байна. Мөн хүчний трансформаторуудыг сольж байгаа. Хамгийн тулгамдсан асуудал нь цахилгаан дамжуулах агаарын шугамууд болоод байна.

Эдгээр шугамыг бид алхам алхмаар шинэчлэх хэрэгтэй. Шинэчилж хараахан чадахгүй байгаа шугамуудын заримынх нь дамжуулах чадварыг өөрчилж, сүүлийн үеийн алдагдал багатай утсаар солих техникийн ажлууд хийгдэж байна. Ингэж бага багаар солих замаар өсөн нэмэгдэж байгаа цахилгааны хэрэглээг хангахаас өөр арга алга. Тендэрийн хуультай холбоотойгоор зарим ажил саатаж байна.

-Өвлийн бэлтгэл ажил хэр хангагдсан бэ?

-Өвөлжилтийн бэлтгэл 97,6 хувьтай хангагдаад байна. Өвлийн их ачааллаас урьтаж хийсэн томоохон ажлуудаас дурдвал, Баянхонгор аймгийн цахилгаан хангамжийн төслийн хүрээнд 110/35/6 кВ-ын Баянхонгор дэд станцад 110/35/6 кВ-ын 6,3 МВА чадалтай Т-1 трансформаторыг 110/35/10 кВ-ын 16 МВА чадалтай трансформатороор солих, 10 кВ-ын ХХБ барих, 10 кВ-ын I секцийн ячеюуд суурилуулах, 5 МВА-ын СВГ төхөөрөмжийг угсарч, ажилд залгасан. Уг ажлын гүйцэтгэгчээр “DMTM” трейд компани ажиллассан бөгөөд 10-р сард ашиглалтад хүлээлгэж өгсөн. Мөн “Мөрөн” дэд станцын ачаалал нэмэгдэж, Т-3 трансформатор 100% орчим ачаалагдаж байгаатай холбогдуулан Баянхонгор дэд станцаас буусан трансформаторыг Мөрөн д/ст руу зөөж, 2,5МВА Т-3 трансформаторыг 6,3 МВА-р сольж суурилуулан 2023 оны 10-р сарын 30-нд хүчдэл дор залгаж, ачаалал өгөөд байна.



Баянхонгор дэд станцын буусан 6.3 МВА трансформаторыг зөөх ажил хийгдэж байгаа нь

110/35/6кВ-ын Өндөрхаан дэд станцын 10МВА Т-1 трансформаторын ачаалал 90%-тай байгаа тул Мөрөн дэд станцаас буусан 2,5МВА трансформаторт зохих үйлчилгээг хийж, Өндөрхаан дэд станц руу шилжүүлэн зөөж, бэлтгэлд авахаар ажиллаж байна.




“Мөрөн” дэд станцаас буусан трансформаторыг зөөвөрлөх ажил явагдаж байгаа нь

Бусад ажил хийгдэхгүй байгаа шалтгаан нь Тендэрийн хуультай холбоотой. Жишээлбэл, Дархан, Улаанбаатарыг холбосон 208 дугаар агаарын шугамын элемент солих ажил хойшилсон. Бид тендер зарлаад компани сонгодогч компаниуд нь хоорондоо үл ойлголцсоны улмаас Сангийн яаманд гомдол гаргадаг. Хуулийн дагуу гомдлыг нь шийдвэрлэх гэсээр байтал цаг хугацаа алдаж намар, өвөлтэй золгоод ажил урагшлахгүй байна. Цаашид Тендэрийн хуулинд өөрчлөлт оруулж, улсын чанартай ажлууд болон эрчим хүчний үндсэн тоноглолуудыг (шугамын тоноглол, хүчний трансформатор, генератор гэх мэт) шууд үйлдвэрээс нь худалдаж авах, ашиглалтын байгууллагууд угсарч хийх тал дээр анхаарч ажиллах нь зүйтэй санагддаг. Ийм зохион байгуулалтыг алхам алхмаар хийвэл эрчим хүчний найдвартай ажиллагааг дээшлүүлэх бололцоотой болно. Хүчний трансформаторт чанар маш чухал атал Тендэрийн хуулиар хамгийн хямд үнийн санал өгснийг нь бид авч байгаа. Ихэнхийг нь Хятадаас авдаг учир тоног төхөөрөмжийн стандарт нь өөр. Үнэ хямд учир овор хэмжээ авсаархан, гэмтлийн гүйдлийн даах хэмжээ бага байдаг нь манайд тохирдоггүй. Манайх хуучны үеийн тоног төхөөрөмжтэй. Түүнийгээ бүрэн шинэчилж чадахгүй, хэсэгчлэн шинэчилдэг учраас тохирдоггүй. Багахангайд өнгөрсөн хавар трансформатор нь гэмтээд 2-3 хоног цахилгаангүй болсон. Бид хаа байсан Мандалговиос трансформатор авчирч цахилгаан залгаж байсан. Иргэдийн утас нь цэнэггүй болж, харилцаа холбоо тасарч, эмнэлэг нь хүртэл хэцүү байдалд орж байгаа юм. Хэрэв ийм явдал олон давтагдвал хүн амын нягтаршил ихтэй газруудад асуудал үүснэ.

-Энэ салбарт олон залуус ажилладаг. Цалин мөнгө тааруу учраас олноор ажлаасаа гарч байгаа гэсэн. Танайх ямар байдалтай байна вэ?

-Залуучууд олноороо ажлаасаа гарч байна. Сурсан мэдсэнээрээ ажиллах гэхээр цалин бага учраас ар гэр нь хэцүүдэх гээд байдаг. Салбарын цалингийн доод хэмжээ 880 мянган төгрөг. Үүнээсээ нийгмийн даатгалаа хасуулна. Ганц бие хүн хүртэл амьдрахад бэрх цалинтай. Инженер нь нэг сая гаруй төгрөгийн цалин авдаг. Ийм бага цалингаар их ажлыг өдөр шөнөгүй хийж байна шүү дээ. Аваар гарлаа гэхэд унтах эрх бидэнд байхгүй. Бид хоорондоо “Хамгийн зоригтой эр бол халуун хөнжлөөсөө дуудагдах” гэж хошигнож ярьдаг. Аваар гарсан үед өөрийнхөө унаагаар ирнэ. Цаана нь хэрэглэгч байгаа учраас бидэнд унтах эрх байхгүй. Улсын компанид ажиллаж, их зүйл сурсан ажилчдыг уул уурхай компаниуд мөнгөөр цохилд авчихдаг. Тэднийг бага ч гэсэн тогтоож аргамжих арга бол цалин шүү дээ. Сүүлийн хэдэн жилд манайх орон сууцны дэмжлэг ажилчдаа үзүүлж чадаагүй. Хашаа байшингийн дэмжлэг гэж гурван сая төгрөг л өгдөг. Бололцоо нь тэр. Хүн байхгүй бол техник нь байгаад ч ажиллахгүй шүү дээ. Эрчим хүчний салбар нь ахмад, дунд, залуу үеийн холбоотой. Ахмад үе маань дунд үеэ боловсруулах, туршлагаа өвлүүлж үлдэх харин дунд үе нь залуу үеэ хамгаалах, ажил мэргэжилдээ дуртай болгох, бахархах сэтгэлийг нь төрүүлэхийг хичээж ажилладаг. Бид айл бүрийн цахилгааныг асааж өгдгөөрөө бахархаж, хийж байгаа ажлаа үнэнчээр хийж, алдаа дутагдал гаргахгүйн төлөө ажилладаг.

Эх сурвалж: "Mongolian Economy" сэтгүүл У.Сарангэрэл



УЛААНБААТАР САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Хөдөлмөрийн аюулгүй байдлын өдөр зохион байгуулав

Сар бүрийн 2 дахь 7 хоногийн мягмар гаригт зохин байгуулагддаг “Хөдөлмөрийн аюулгүй байдлын өдөр”-ийг 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж, ажилтнууд танхимын болон цахим хэлбэрээр хамрагдсан. Тус өдрөөр техникийн хяналтын инженер Л.Мөнхцогж “Хамгаалалтын зурвасын тухай, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд”, МСЭЛ ХХК-ийн реле хамгаалалт, автоматикийн инженер Д.Энхзориг “Реле хамгаалалт автоматикийн шинэчлэлийн ажлаар шинээр суурилуулсан релений тухай, АҚ-205 гарсан шугамын хамгаалалт болон АҚ-101 нумын хамгаалалт түүний ашиглалтын талаар”, Ард даатгал ХХК-ийн менежер Ц.Билгүүн “Гэнэтийн ослын даатгалын талаар” сургалт, танилцуулга хийж, зөвлөгөө өгөв. Мөн Захиргаа, аж ахуйн албаны хуулийн зөвлөх М.Мөнхчимэг, хүний нөөцийн мэргэжилтэн Б.Болормаа нар “ЦДҮС ТӨХК-ийн дотоод журам” холбогдох заалтуудыг тайлбарлаж, ажилтнуудад мэдээлэл өгсөн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн III шатны үзлэг

Улаанбаатар салбарын ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу нийт 16 ажлын байранд 3 дугаар улирлын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн III шатны үзлэг, шалгалт явуулж, үзлэгт 125 ажилтан хамрагдаж, давхардсан тоогоор 65 үүрэг даалгаврыг тайлан хэлбэрээр холбогдох албадуудад танилцуулж, цаашид хийгдэх ажлын төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг нь хангуулж, гүйцэтгэлийг нь шалган ажиллаж байна.



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 3-р шатны үзлэгийн үеэр

Хяналт шалгалт

Дэд станцуудын өргөтгөл, шинэчлэлийн ажил гүйцэтгэх гадны байгууллагын ажилтнуудад аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллаж байна. Үүнд: Цэвэрлэх дэд станцын шинэчлэлийн ажил гүйцэтгэж байгаа Вилл Вест ХХК, Сонгино дэд станцын хамгаалалтын зурваст их чадлын хуримтлуурын ажил гүйцэтгэх Смарт плас ХХК, 110 кВ-ын өргөтгөлийн ажлаар тоноглолуудын суурийн ажил гүйцэтгэх Сора Хашира ХХК, Дундгол дэд станцын хамгаалалтын зурваст газар шорооны ажил хийх Грин энерги ХХК, салбарын оффисын барилгын цонхны жийрэг резин солих Стар хаус ХХК, Сонгино дэд станцын 110 кВ-ын ИХБ-ийн өргөтгөлийн ажилтай холбоотой шав тавьж, улаан шугам татах ажил гүйцэтгэх Монхорус ХХК, 107,108 дугаар агаарын шугамын тулгуур №13-14 хооронд машин механизмаар Улиастай голын төмөр бетон гүүрийн барилга угсралтын ажил гүйцэтгэх Туулын гүүр далай ХХК, Буянт-Ухаа дэд станцын Т-1,2 трансформаторт туршилт хийх МСЭЛ ХХК, 109,110 дугаар агаарын шугамын тулгуур №27-28 хооронд хамгаалалтын зурваст газар шорооны ажил хийж дулааны шугам татах Билгүүн-Од констракшн ХХК, Багахангай дэд станцын барилгын дээврийн засварын ажил гүйцэтгэх Мөнхийн баянгал ХХК, Туул, Дорнод-2 дэд станцуудын барилгын дээврийн их засварын ажил гүйцэтгэх Дэлгэрмөрөн групп ХХК-ийн ажилтнуудад тус тус аюулгүй ажиллагааны тухайлсан зааварчилгаа өгч, ажлын явцад хяналт шалгалт хийж, аюулгүй ажиллагааг хангуулж ажиллаж байна.

Хамгаалалтын зурвас

Хамгаалалтын зурваст ажиллах гадны байгууллагын ажилтнуудад зааварчилгаа өгч, зарим ажлуудад тасралтгүй хяналт тавьж ажиллаж байна. Үүнд: 110 кВ-ын 111,112-р агаарын шугамын тулгуур №21-22-ын хооронд хашаа барьсан Үүр тээл ХХК, 105,106-р агаарын шугамын тулгуур №3-ын доор ажил гүйцэтгэж байсан Алтан тайж ХХК, 110 кВ-ын 127,128-р агаарын шугамын тулгуур №145-ын хийц хэсэгт төмөр хашаа барьж гагнасан NTN

ХХК, 220 кВ-ын 211,212-р агаарын шугамын тулгуур №1-2-ын хооронд, 110 кВ-ын 111,112-р агаарын шугамын тулгуур №22-23-ын хооронд, 110 кВ-ын 109,110-р агаарын шугамын тулгуур №2-3-н хооронд авто зогсоол төлөвлөсөн Зөөлөн зааг ХХК, 110 кВ-ын Яармаг А,Б агаарын шугамын тулгуур №5,6-ийн хооронд зогсоол барьсан Электрик ком ХХК-ийн зөрчилд тус тус шаардлага тавьж, улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.



Ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулав

Монгол Улсад Эрчим хүчний салбар үүсч хөгжсөний 100, 101 жил, ЦДҮС ТӨХК-ийн 55 жилийн ойг тохиолдуулан шуурхай ажиллагааны ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, ажлыг аюулгүй гүйцэтгэх арга барилыг дээшлүүлэх, салбарын харьяа дэд станцуудад ажиллаж байгаа ажилтнуудын ажлын уялдаа холбоо, хамт олны дундах уур амьсгалыг сайжруулах зорилгоор ажил мэргэжлийн уралдааныг 2023 оны 09 дугаар сарын 19-21, 10 дугаар сарын 19-ний өдрүүдэд тус тус зохион байгууллаа. Ажил мэргэжлийн уралдаан батлагдсан удирдамжийн дагуу 5 үе шаттайгаар 4 өдөр

зохион байгуулагдаж, 100 багийн 236 ажилтан авхаалж самбаа, мэдлэг, ур чадвараа сорин оролцсон бөгөөд ажилтан үе бүрээс 10 оноо нийт 50 оноо цуглуулах ба цуглуулсан оноогоор жагсааж, тэмцээний эхний 5 байрыг шалгаруулж урамшуулсан.

Уралдааныг өртөөчилсөн байдлаар зохион байгуулж, оролцсон ажилтнуудын онол практикийн мэдлэгийг сорьсон нь ажлын байрны бодит сургалт болсон.



Ажил мэргэжлийн уралдааны явц

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

220/110/35 кВ-ын Улаанбаатар дэд станцын АТ-1 автотрансформатор, 110/35/10 кВ-ын Яармаг дэд станцын Т-1, 2 трансформатор, 110/10 кВ-ын Амгалан дэд станцын 33 нэр төрлийн тоноглолд урсгал засварын ажил хийж гүйцэтгэсэн.



Амгалан дэд станцын тоноглолуудад



Улаанбаатар дэд станцын АТ-1



Цэвэрлэх дэд станцын Т-2

220/110/35 кВ-ын Сонгино дэд станцын 220 кВ-ын ХТ-1-н В фазад TYD220/√3 V-0.01GH маркийн ХТ суурилуулах ажил, 110/35/10 кВ-ын Налайх дэд станцын Т-1-н 110 кВ-ын ТТ-г LW36-126W/T3150-40 маркийн таслуураар солих ажил хийж гүйцэтгэсэн.



Налайх дэд станцын таслуур сольж байгаа нь



Сонгино дэд станцын 220 кВ-ын ХТ сольж байгаа нь

Эрдэм транс ХХК-тай хийгдсэн гэрээт ажлын дагуу 109,110-р АШ-ын тулгуур №11-14-

н хооронд трасс шилжүүлэх ажил бүрэн хийж дууссан.



220 кВ-ын Багануур - Бөөрөлжүүт ЦДАШ-ын барилга угсралтын ажлаар нийт 51 анкер тулгуур угсарч босгосон. Тулгуур №1-32 хүртэл 6 фазын дамжуулагч утас хөвж татах, тулгуур №1-32-д аянгын трасс, тулгуур №1-16-д хос трасс, тулгуур №16-32-д ТК-70 маркийн аянга хамгаалах трасс татах, 209,210-р АШ-ын тулгуур №182-д, 220 кВ-ын Бөөрөлжүүт АШ-ын тулгуур №34-51-д OPGW-48 маркийн шилэн кабель хөвж татах, 220 кВ-ын Бөөрөлжүүт АШ-ын тулгуур №34-51-д 6 фазын утас татах, шинээр барьсан 220 кВ-ын Бөөрөлжүүт АШ-ыг 209,210-р АШ-ын тулгуур №32 руу холбож трасс шилжүүлэх, тулгуур №15,16,42-д суурийн облом бетоноор цутгах ажил тус тус хийж гүйцэтгэсэн.

ЗӨБС-ын харьяа 220/110/35 кВ-ын Багануур дэд станц өргөтгөлийн ажлаар 209-р АШ-ын

ЭТ, ГТ, ШуС, ТойС, ШинС-1, 210-р АШ-ын ЭТ, ГТ, ШуС, ТойС, ШинС-2-н суурь тавих, төмөр хийц хөл угсрах, тоноглол суурилуулах, давтан газардуулга хийх, ШХТ холболтыг өөрчлөх, ШХТ-н болон 210-р АШ-ын ЭТ шилжүүлэх, шинийн холболт хийх, I,II-СШ-н холболт хийх ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэсэн.



Мэдээллийг бэлтгэсэн: Захиргаа, аж ахуйн албаны ахлах бөгөөд дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Т.Аюуш

ТӨВИЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

ТБС-ын гамшгийн эмзэг байдлын эрсдэлийн үнэлгээ хийж байгаа "ДАТ КОНСАЛТИНГ" ХХК-ийн шаардсан судалгааны материалыг гарган өгч 2023.09.22-25-ны өдрүүдэд тус компанийн төлөөлөл 3 мэргэжилтэнгийн хамт ажилласан. Салбарын 11 дэд станц, 220/110кВ-ын эрсдэл бүхий объект бүрд очиж танилцсан. Шаардлагатай материал болон аудитын зөвлөмжид оруулах саналыг нэгтгэн гаргаж өгсөн.

Салбарт шинээр ажилд орсон 5 ажилтан дадлага хийж буй 7 оюутанд урьдчилсан зааварчилгаа өгсөн. Мөн 6 ажилтнаас шалгалт авч шийдвэр гаргаж ажилласан.

Салбарын харьяа 18 дэд станцад IV улирлын ажлын байрны III шатны үзлэгийг 2023.10.11-18-ны хооронд хийж гүйцэтгэлээ. Батлагдсан удирдамжийн дагуу ажлын байрны үзлэг, өвлийн бэлтгэл ажлын гүйцэтгэл, үндсэн хөрөнгийн хяналтын тооллого зэргийг шалгасан. Үзлэгийг ерөнхий инженерээр ахлуулсан ажлын хэсэг нь нэг загварын хяналтын хуудсаар 18 дэд станцад үнэлгээ үзлэг шалгалт хийсэн.

Өмнөх III улирлын үзлэгээр илэрсэн зөрчлийг 92%, өвлийн бэлтгэл ажлын гүйцэтгэл 85% хийгдсэн ба үлдсэн ажил нь цаг хугацааны хувьд хүлээгдэж байна. Үзлэгийн нэгдсэн тайланг гаргаж даргын зөвлөлд танилцуулсан ба 25 санал хүсэлтийг удирдлагуудад тавьсан юм.

1. ЭХЯ-ны Улсын ахлах байцаагчийн №11-00-01-003/13 тоот АЛБАН ШААРДЛАГА -ын хүрээнд хийгдсэн ажлын тайланг ЭХЯ болон ХМХ-т албан тоотоор явуулсан.



2. Дархан-Уул аймгийн ЗДТГ-аас ирсэн өвлийн бэлтгэл ажил, үер уснаас урьдчилан сэргийлэн ажиллах тухай АЛБАН ДААЛГАВАР -ын хариу тайланг ДУА-ын захирагчийн албанд албан тоотоор явуулсан. ЭХЯ, ЦДҮС ТӨХК, ДУА-ын ЗДТГ-аас ирсэн албан тоот үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь ажил зохион байгуулж тайланг хугацаанд нь гарган ажиллаж байна.



3. САЛБАРЫН АВААР ЭСЭРГҮҮЦЭХ ДАСГАЛЫГ "113-р АШ-ын Т№19-20 аянгын тросс тасарч 3 фазын богино залгаа болж

станц тусдаа гарсан" үед авах арга хэмжээ авах сэдвээр 2023.09.23-ний өдөр зохион байгуулсан. Дасгалыг транзит дэд станцуудын хүрээнд өргөтгөж зохион байгуулж үр дүнтэй амжилттай зохион байгууллаа. Үүсгэгч ТЭЦ-



4. ДДЦС-ууд тусдаа гарсан үед синхрон хийж залгах мөн 110кВ-ын шилэн кабель, нөөц тулгуургүй зэрэг асуудлыг хөндөж гаргаж ирсэн.



4. Ажилтнуудынхаа эрүүл мэндэд анхаарч, дасгал хөдөлгөөн хийх, спортоор хичээллэх, зөв хооллох хандлагыг төлөвшүүлэх, энэ онд хийсэн бүтээлч ажлаа дүгнэн танилцуулж алдаршуулах мөн хамт олны эв



нэгдлийг эрхэмлэх, залуу тамирчдыг тодруулах зорилготой ЗАСВАРЫН АЖЛЫН ХААЛТ -ын өдөрлөгийг 2023.10.06-ны өдөр салбарын нийт ажилтнуудын дунд зохион байгууллаа.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР


110кВ-ын Ерөө-Бугант ЦДАШ-нд хэт хүчдэл хязгаарлагч суурилуулсан

1. Ерөө АШ-ыг таслаж ажилласан хугацаа:

д/д	Тоноглол нэр	Хугацаа	
		Сар өдөр	Цаг минут
1	Ерөө-Бугант АШ-ын Ту№71-60 хооронд хийж гүйцэтгэсэн.	Х/11	08:00\19:00
2	Ерөө-Бугант АШ-ын Ту№59-37 хооронд хийж гүйцэтгэсэн.	Х/12	08:00\19:00
3	Ерөө-Бугант АШ-ын Ту№45-37 хооронд хийж гүйцэтгэсэн.	Х/13	08:00\19:00

2. Хийгдсэн ажил

110кВ-ын Ерөө-Бугант ЦДАШ-ын ТУ№37-71 (трассын урт 78-87км)-ын хооронд С фазад хэт хүчдэл хязгаарлагч суурилуулах ажлыг 19 хүний бүрэлдэхүүнтэй 2 бригад хийж гүйцэтгэсэн.




5. 110/35/6 кВ Зүүнхараа, 110/35/10 кВ Баруунхараа, Орхон дэд станцуудын хэмжүүрийн их засварын ажлыг 2023.08.23-09.13-ны хооронд хийж гүйцэтгэсэн. Их засварын ажлын хүрээнд нийт Satet PM130EH маркийн хэмжүүр 34 ширхгийг авч суурилуулан, VPN сүлжээнд холбосноор салбарын диспетчер горим, ачаалалд хяналт тавих боломж бүрдсэн.

6. ЦДҮС ТӨХК-ийн 2023 оны 09 сарын 19-ний 01/1314 тоот албан бичгийн дагуу өвлийн их ачааллын АЧР-н тавил шалгах ажлыг 2023.09.25-28-ны хооронд хийж гүйцэтгэв.

7. 2023.10.11-19-ний хооронд салбарын харьяа 18 дэд станцуудын 325 ширхэг тоолууруудын цаг тохируулах ажлыг графикийн дагуу хийж гүйцэтгэсэн.



Мэдээллийг бэлтгэсэн:
Захиргаа, аж ахуйн албаны
дарга Б.Баяр



ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 09, 10 дугаар саруудад дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Ээлжит шалгалт: Салбарын хэмжээнд шинээр ажилд орсон болон 7 ажилтанд дагалдан суралцах программ гарган өгсөн бөгөөд шалгалтын комисс тухай бүрт нь шалгалтуудыг авч 2 ажилтныг жинхлүүлэн, 1 ажилтанд шинээр групп олгон, 3 ажилтны группийг ахиулсан байна.

Наряд, шийдвэрээр хийсэн ажил: Салбарын харьяа нийт 12 дэд станцын тоног төхөөрөмжүүд болон 110кВ, 220кВ-ын ЦДАШ-уудад нарыдаар 59, шийдвэрээр 101 удаагийн ажил гүйцэтгэж, зөрчил дутагдалгүй ажиллалаа.

Ажил гүйцэтгэх бригадуудын нийт 593 ажилтанд тухайлсан зааварчилгааг өгч ажилласан байна.

Дасгал, зааварчилгааны талаар: Шинээр ажилд орсон 7 ажилтанд урьдчилсан зааварчилгаа, 8 ажилтанд ажлын байрны анхан шатны зааварчилгаа, 1494 ажилтанд өдөр тутмын зааварчилгаа, 96 ажилтанд сар бүрийн ээлжит зааварчилгаа, ээлжит бус зааварчилгааг 88 ажилтанд, тухайлсан зааварчилгааг 509 ажилтанд тус тус өгч ажилласан байна.

Салбарын алба, хэсэг, дэд станцууд дээр аваар эсэргүүцэх дасгал 4 удаа хийгдэж нийт 55 ажилтан, гал эсэргүүцэх дасгал 4 удаа хийгдэж нийт 55 ажилтан, осол эсэргүүцэх дасгал 3 удаа хийгдэж нийт 23 ажилтан тус тус хамрагдсан байна.


ХАБЭА-н бүх шатны үзлэг: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг давхардсан тоогоор 42 удаа хийж 70 зөрчил, II шатны үзлэгийг 11 удаа хийж 31 нэрийн зөрчил, III шатны үзлэгийг 10 удаа хийж 71

зөрчлийг илрүүлэн нийтдээ 104 зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг авч ажиллалаа.

2023 оны 10-р сарын 04-нөөс 09-ний өдрүүдэд Хишиг-Өндөр, Сансар, Хархорин, Цэцэрлэг, Арвайхээр, Баянтээг, Баянхонгор дэд станцуудад ХАБЭА-н III шатны үзлэг шалгалт хийх, эрх шилжсэн ажлууд хүлээж авах, галын болон хамгаалах хэрэгслүүд хүлээлгэн өгөх ажлуудаар 6 хоног ажиллаж, илэрсэн зөрчлүүдийг устгах хугацаатай даалгавар өглөө.



Бусад ажлын талаар: Орхон аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, ХАБЭА-н зөвлөл хамтран зохион байгуулж буй "Ослыг тэглэх алсын хараа" сэдэвт сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх хэлэлцүүлэгт орон тооны бус байнгын комиссын 4 ажилтныг хамрууллаа.



Компаниас нийлүүлэгдсэн хамгаалах хэрэгсэл болон галын багаж хэрэгслэлүүдийг дэд станцуудад хуваарилан зохих түвшинд нь оруулж тавьсан.

Эрдэнэт дэд станцын 40МВа-н трансформаторыг 63 МВа-н трансформатороор солих болон 35кВ-н ИХБ-н өргөтгөлийн ажилд байнгын хяналтыг тавьж Т-1 (Х/03-нд), Т-2 (ИХ/23-нд) трансформаторуудыг амжилттай залгалаа.



110 кВ-н Хархорин-Цэцэрлэг ЦДАШ-н хамгаалалтын зурвас дотор самбар байрлуулсан зөрчлийг арилгуулах талаар Архангай аймгийн засаг дарга болон ТМС-уудад 02/368 албан тоот хүргүүлсэн.

110 кВ-ын Мөрөн-Тэлмэн ЦДАШ-н тулгуурын утасан доогуур гарахдаа өвс ачсан машины өвс нь шатсан талаарх мэдээллийн дагуу Хөвсгөл аймгийн ОБГ-т 02/354 албан тоот хүргүүлээ.

110/35/10/6кВ-ын Баянхонгор болон 110/35/6кВ-ын Мөрөн дэд станцуудын өргөтгөлийн ажлуудад байнгын хяналтыг тавьж ажиллаж байна.



Мэдээлэл бэлтгэсэн: ХАБЭА-н инженер М.Бат-Эрдэнэ

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Засварын ажлын явц:

- Их засварын тодотгосон төлөвлөгөөний дагуу нийт гүйцэтгэл 74 нэр төрлийн ажлаас 69 ажил хийгдсэн 93,24 хувийн биелэлттэй.
- Урсгал засвараар 85 нэр төрлийн ажлаас 79 нэр төрлийн ажил хийгдсэнээр 93 хувийн биелэлттэй.
- ТЗБАХ-ний тодотгосон төлөвлөгөөний дагуу 14 нэр төрлийн ажлаас 11 ажил хийгдэж 78,5 хувийн биелэлттэйгээр тус тус гүйцэтгэсэн.

Салбарын хэмжээнд хэрэгжиж байгаа өргөтгөл шинэчлэлийн ажлуудын тухай:

1. 220/110/35/6 кВ-ын Эрдэнэт дэд станцын Т-1,2 трансформаторыг солих, ИХБ-35 кВ-ыг 2 гаргалгаагаар өргөтгөх ажил

Өргөтгөлийн ажлын хүрээнд 110/35/6 кВ-ын 40 МВа-ийн Т-1, Т-2 трансформаторыг 63 МВа чадалтай трансформатороор, 110, 35 кВ талын холболтын тоноглолууд, 6 кВ талд гүйдлийн трансформаторууд, 35 кВ-ын шинийн дамжуулагч, шинийн порталуудыг солигдоно, ШДХ шинэчлэгдэнэ. "Зэс-Эрдэнийнхувь ХХК"-ийн 2 гаргалгаа шинээр хийнэ.

- Захиалагч – "Зэс Эрдэнийн хувь ХХК"
- Ерөнхий гүйцэтгэгч – "Смарт пласс ХХК"
- Зураг төсөв хийсэн: "Смарт пласс ХХК"
- Хугацаа: эхлэх- 2022-09-01, дуусах-2024-05-30
- Хөрөнгө оруулалт: "Зэс Эрдэнийн хувь ХХК"
- Төсөвт өртөг: 10,6 тэрбум

Хэрэгжиж байгаа ажлын явц:

- 63 МВа-ийн Т-1,2 трансформаторыг шинээр суурилуулан ажилд оруулсан.
- 35 кВ-ын ШДХ-1,II-ыг иж бүрэн панель, реле хамгаалалтын төхөөрөмжүүдийг шинэчлэн ажил оруулсан.
- 35 кВ-ын Зэс-А,Б гаргалгааны тоноглолыг суурилуулах ажил хийгдсэн.
- Өргөтгөлийн ажилд шинэчлэгдэхээр тусгагдсан бусад тоноглолуудыг 2024 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

Өргөтгөлийн ажлын онцлог давуу талууд:

- Эрдэнэт дэд станцын суурилагдсан хүчин чадал нэмэгдсэн
- Станцын тоноглолын найдвартай ажиллагаа дээшилсэн
- Их ачааллын улиралд нэг трансформатортой горимд ажиллах боломжтой болсон.



Шинээр суурилагдсан трансформаторын байдал



Өргөтгөлийн ажлын хүрээнд шинэчлэгдэх тоноглолын схем



35 кВ-ын Зэс-А, Зэс-Б гаргалгааны тоноглолын байдал

2. Баянхонгор дэд станцад өргөтгөл шинэчлэлийн ажил хийх

Т-1,2-ыг 110/35/10 кВ-ын 16 МВа чадалтай трансформатораар солино, Т-3 трансформаторын 110 кВ талын гаргалгаа шинээр хийгдэнэ. Т-1,2-ын 110, 35 кВ талын тоноглолууд солигдоно. 10 кВ-ын ХХБ шинээр баригдана. Т-1,3-ын РХА шинэчлэгдэнэ. НМ1 тавигдана.

- Захиалагч: Баянхонгор аймгийн ЗДТГ
- Ерөнхий гүйцэтгэгч: "ДМТМ трейд ХХК"
- Зураг төсөв хийсэн: "Баясалтөгс ХХК"
- Хугацаа: эхлэх -2022-09-21, дуусах-2024-12-01

- Хөрөнгө оруулалт: Улсын төсвийн хөрөнгө
- Төсөвт өртөг: 13,3 тэрбум

Хэрэгжиж байгаа ажлын явц:

- 16 МВа-ийн Т-1 трансформатор солигдсон. Реле хамгаалалтын хамт.
- 10 кВ-ын ДХТ-1 трансформатор солигдсон
- 10 кВ-ын СВГ-1 шинээр суурилагдсан.
- 10 кВ-ын секцийн ячейкууд шинээр суурилагдсан. Реле хамгаалалтын хамт
- Т-1 трансформаторын 110, 35, 10 кВ-ын тоноглолууд солигдсон. РХА-ийн төхөөрөмжүүдийн хамт

Өргөтгөлийн ажлын онцлог давуу талууд:

- Дэд станцын суурилагдсан хүчин чадал нэмэгдсэн
- Станцын тоноглолын найдвартай ажиллагаа дээшилсэн
- Их ачааллын улиралд нэг трансформатортой горимд ажиллах боломжтой болсон.
- 35, 10 кВ-ын шин дээрх хүчдэлийн түвшинг НСД-ийн зөвшөөрөгдөх утгад барих, ЦЭХ-ний чанарын түвшин дээшилсэн.



16 МВа-ийн Т-1 трансформаторын зураг

10 кВ-ын хаалттай хуваарилах байгууламж шинээр баригдсан.



10 кВ-ын ячейкууд шинээр суурилагдсан

3. Хөвсгөл аймгийн Мөрөн суманд 10 МВа-ийн НЦС-ыг ЭХНС-д холбох оруулах

110/35/6 кВ-ын Мөрөн дэд станцын өргөтгөл – Азийн хөгжлийн банкны хөрөнгөөр Хөвсгөл аймгийн Мөрөн сумд баригдах 10 МВт-ын Нарны цахилгаан станцын төслийн хүрээнд Мөрөн дэд станцыг өргөтгөж 1 хэлхээ ЦДАШ-ыг шинээр холбох, дэд станцын барилгыг өргөтгөх ажил хийгдэж байна. Үүнд:

- Захиалагч – Эрчим хүчний яам
- Ерөнхий гүйцэтгэгч – XIAN ELECTRIC ENGINEERING CO.,LTD, "Шан ХД электрик инженеринг" CO6.,LTD
- Зураг төсөв хийсэн: "Смарт пласс ХХК"
- Хугацаа: 2023-2024
- Төсөвт өртөг: 89,9 сая

Хэрэгжиж байгаа ажлын явц:

- Өргөтгөлийн хүрээнд суурилагдах 110 кВ-ын тоноглолын суурийн ажил хийгдэж байна
- Барилгын өргөтгөлийн ажил хийгдэж байна.



110 кВ-ын тоноглолын суурийн ажил

Мэдээлэл бэлтгэсэн: Засварын инженер Г.Ууганбаяр

ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

2023 оны эхнээс урьдчилсан зааварчилгаанд шинээр ажилд орсон 26 ажилтан, сарын давтан зааварчилгаанд 1411 ажилтан, ээлжит бус зааварчилгаанд 1465 ажилтан, тухайлсан зааварчилгаанд 3393 ажилтан, өдөр тутмын давтан зааварчилгаанд 17375 ажилтан давхардсан тоогоор тус тус хамрагдаж аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Нийслэлийн засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг шалгалтад Багануур дүүргийн ЗДТГ, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиуд, Засаг захиргааны нэгжүүд, томоохон аж ахуй нэгж гэх мэт 60 байгууллага 2023 оны 10 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд хоёр үе шаттай 18 чиглэлээр шалгаж 0-100 хүртэлх оноогоор үнэлж шалгахад тус салбарын гамшгаас хамгаалах штаб мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн 90.9 оноогоор "ДҮҮРЭН ХАНГАЛТТАЙ" дүгнэгдэж, шилдэг зургаан байгууллагын нэгээр шалгарч, талархлын "Өргөмжлөл"-өөр шагнагдав.



Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдрийг тохиолдуулан "ХЭН Ч, ХААНА Ч, ХЭЗЭЭ Ч БЭЛЭН БАЙ", Анхны тусламжийн нөхөрлөлүүдийн буухиа тэмцээнд салбарын АТН-ийн "ЗӨВ" баг тэргүүн байр эзэлж шилжин явах цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдав.



220 кВ-н Бөөрөлжүүт ЦДАШ-н Багц-1 барилга угсралтын ажлын хүрээнд АНЭ1-ээс АНЭ34-ийн хооронд аянгын тросс татах, арматур тогтоох, 261, 262-р АШ-ын ТНЭ179-188 хооронд 6 фазын утас сунгах, татах, бэхэлгээ хийх ажлуудыг хийж гүйцэтгэх УБС-ын ЗА-ны 18 ажилтанд тухайлсан зааварчилгаа өгч таван машин механизм бүхий бригадын ажилд 2023 оны 10 дугаар сарын 13-наас 21-ний өдрүүдэд хяналт тавьж ажилласан.



110/35/6 кВ-н Бор-Өндөр дэд станцын 110/35 кВ-н ИХБ болон кабелийн туннельд үүрэлсэн мэрэгч амьтан устгах хор цацах ажлыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, 2023 оны 06 сарын 30-наас 10 сарын 13-ны өдрүүдэд хийж гүйцэтгүүлэв.



110/35/6 кВ-н Өндөрхаан дэд станцад 2023 оны 10 сарын 20-ны шөнийн 03:20 минутад гадны байгууллагын хүмүүсийн буруутай үйл ажиллагаанаас болж 6/0.4 кВ-н ДХТ-н 6 кВ-н шинэнд барилгын хог хаягдал тугалган цаас хийсэж ирэн 3 фазын богино залгаа гарч 6 кВ-н нэвтрэх болон хөндийрүүлэх тусгаарлагч, цэнэг шавхагчууд шатсан тасралтын гэмтлийг богино хугацаанд арилгаж схем сэргээсэн, зөрчлийн актыг судалж бүртгэн хяналт мониторингийн хэлтэст хүргүүлсэн.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЗШЛҮҮЛЭХ ТАЛААР

Засварын ажлын талаар:

1. 2023 оны тодотгосон төлөвлөгөөт их засварын 18 ажлаас / 258,97 сая төг /17 ажил хийгдэж гүйцэтгэл 94 хувьтай байна.

Хийгдээгүй ажил:

1. CLW Донгпенг автокран явах эд ангийн засвар 58-21 УБМ
2. Айраг дэд станц тогтмол гүйдлийн панелейн хяналтын дэлгэцийн тэжээлийн блок солих
2. 2023 оны тодотгосон төлөвлөгөөт ТЗБАХ-н 20 ажлаас /3,563,3/ 12 ажил хийгдэж 60 хувьтай.

Хийгдээгүй ажлууд:

1. Чойр хэсэгт гүний худаг гаргах, худгийн барилга шинээр барих
2. Чойр шинээр контор барих ажлын зураг хийлгэж батлуулах
3. Замын-Үүд дэд станцад аккумуляторын батарей шинэчлэх.
4. Борхойн дэд станц 10 кВ-н ДХТ-1 шинэчлэх
5. Багануур дэд станцад 220 кВ АТ-1 Гүйдлийн тр шинээр суурилуулах
6. Багануур дэд станцад 220 кВ АТ-2 Гүйдлийн тр шинээр суурилуулах
7. Багануур дэд станцад 220 кВ ХТ-1 ШинС шинээр суурилуулах
8. Багануур дэд станцад 220 кВ ХТ-2 ШинС шинээр суурилуулах
9. Хөрөнгө оруулалтын ажлаар 10 ажлаас /283,0/ 10 ажил хийгдэж 100 хувьтай.
10. 2023 оны төлөвлөгөөт урсгал засварын 87 ажлаас 86 ажил хийгдэж 99 хувьтай.
11. Замын-Үүд дэд станцын ОПУ-н байрны шалны халаалт хийгдээгүй байна.
12. АТД ажлаар 121 ажлаас давхардсан тоогоор 208 ажил хийгдсэн.
13. Аянган улирлын бэлтгэл ажлын 26 ажлаас 26 ажил хийгдэж 100 хувьтай.
14. Гэмтэл устгах ажил өссөн дүнгээр 56 ажил хийгдээд байна

Мөн Төв, Хот, Өндөрхаан, Чойр, Айраг, Бор-Өндөр, Сайншанд дэд станцуудад батлагдсан өвлийн горимын дагуу АЧР-н тавил тохируулж, ажиллагааг шалгах ажлыг 2023.10.02-03-ны өдрүүдэд гүйцэтгэсэн. Төв дэд станцад яЧНЭ36 6кВ-н таслуурыг АЧР-с гаргаж, Бор-Өндөр дэд станцад яЧНЭ35 6кВ таслуурыг АЧР-т нэмж

оруулсан. АЧР шалгасан тайланг нэгтгэж РХАХТ-н хэлтэст явуулсан.

Багануур дэд станцад шинээр суурилуулсан 220кВ-н тоноглолуудад хэмжилт туршилт хийж, газардуулгын хүрээний эсэргүүцэл хэмжсэн. Шинээр барьсан 220кВ-н 261, 262-р АШ-н ТНЭ1-51 тулгууруудын газардуулгын эсэргүүцлийг хэмжсэн.

Ашиглалт шуурхай үйлчилгээний албаны чиглэлээр:



Багануур дэд станцын 220 кВ-н ИХБ-н шинээр суурилуулсан тоноглолууд болон 209, 210-р АШ-ын тулгуур №282-313 хоорондох шинээр хийгдсэн шугамыг туршилтын хүчдэл дор залгаж цаашид ачаалал өгөх 291 үйлдэлтэй сэлгэн залгалтыг 10-р сарын 17,18,19-ний өдрүүдэд хийж амжилттай дуусгасан. Сэлгэн залгалтыг нийт шуурхай ажиллагааны 8 ажилтан гүйцэтгэж 6 ажилтан хяналт тавьж ажилласан.



Өвлийн их ачааллын горимд шилжсэн тухай: Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Зүүн-Өмнөд бүсийн салбар нь компаниас ирсэн 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 01/1314 тоот 2023-2024 оны өвлийн их ачааллын горимд шилжих тухай албан бичгийн дагуу харьяа дэд станцуудыг өвлийн их ачааллын горимд 2023

оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 09 дүгээр сарын 26-ны өдрийн хооронд шилжүүлж тайланг ТБТХ-т хүргүүлсэн.

Сургалтын чиглэлээр:

2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр Эрчим хүчний салбарт төсөл хэрэгжүүлэхэд үнэлгээ хийх



ХБНГУ-ын 6 хүний бүрэлдхүүнтэй баг ЦДҮС ТӨХК-ийн Зүүн-Өмнөд бүсийн салбарын сургалтын баазтай танилцсан. Салбарын сургалтын төвийн үйл ажиллагааг тус салбарын Захиргаа аж ахуйн албаны сургалт, бүтээмжийн инженер Б.Ариунжаргал, Инженерийн албаны засварын инженер Г.Алтангэрэл, РХАХТА-ны ахлах бөгөөд нийлмэл РХА-н инженер Б.Мягмарсүрэн нар танилцуулав.

Олон нийтийн чиглэлээр:


Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хороо үүсэн байгуулагдсан 40 жилийн ойн нэрэмжит "Волейбол"-ын тэмцээнд эмэгтэй М.Санчирмаа ахлагчтай – Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Зүүн-Өмнөд бүсийн салбарын баг тамирчид алтан медаль хүртэж "Тэргүүн байр" эзэллээ.



Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хороо үүсэн байгуулагдсан 40 жилийн ойн нэрэмжит "Сагсан бөмбөг"-ийн тэмцээнд Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Зүүн-Өмнөд бүсийн салбар Эрэгтэй Б.Пүрэвсүрэн ахлагчтай, Эмэгтэй Б.Ганчулуу ахлагчтай баг тамирчид хос алтан медаль хүртэж "Тэргүүн" байр эзэллээ.



Мэдээллийг бэлтгэсэн: Мэдээллийн технологи, компьютерын инженер Б.Пүрэвсүрэн



ГОВИЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд 2023 оны 09, 10 дугаар сард нарыдаар 53, шийдвэрээр 68 ажил хийгдсэн. Наряд, шийдвэрээр ажил гүйцэтгэхэд ажлын аюулгүй байдлыг хариуцагчид болон бригадын бүрэлдэхүүнд онцгой анхаарч, шат шатны зааварчилгааг чанартай өгч, аюулгүй ажиллах арга барилд хяналт тавьж ажилласан.

Салбарын хэмжээнд 19 удаагийн дасгал зохион байгуулагдаж 126 ажилтан хамрагдсан ба сарын давтан зааварчилгааг 153, тухайлсан зааварчилгааг 957, ээлжит бус зааварчилгааг 168 ажилтанд өгсөн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг 471 удаа хийж 38 зөрчил, II шатны үзлэгийг 25 удаа хийж 59 зөрчил, III шатны үзлэгийг 1 удаа хийж 94 зөрчил илрүүлэн устгаж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч ажилласан. Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг 67 удаа хийсэн.

2023 оны III улирлын ХАБЭА-н III шатны үзлэгийг 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс 09 дүгээр сарын 19-ний өдрийн

хооронд дүрэм журмын хэрэгжилт, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн ажил, ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн ашиглалт, техникийн бичиг баримт бүрдүүлэлт, хөтлөлт, өндрийн ажлын аюулгүй ажиллагаа, галын аюулгүй байдал, дотоод хяналт /нарядын системийн мөрдөлт, СЗ-н хуудсын ашиглалт, ША-ны схем/ зэргийг шалгаж, дэд станцын анхдагч хэлхээний тоноглолуудад үзлэг хийж, үүрэг даалгавар өгч, ажилтнуудын санал хүсэлтийг авч, зөвлөгөө өгч ажилласан.

Өмнө II улирлын үзлэгээр илэрсэн зөрчлийг арилгасан байдал, өгсөн үүрэг даалгаврын биелэлт 75%-тай дүгнэгдсэн. Иймд алба, хэсэг, дэд станцуудын дарга, ахлах инженерүүд III улирлын үзлэгийн зөрчил арилгах, үүрэг даалгавар биелүүлэх ажлын төлөвлөгөөг дэлгэрэнгүй, хариуцах албан тушаалтныг тодорхой зааж, биелэлтийг цаг хугацаанд нь зураг, материалаар баяжуулан, дэлгэрэнгүй гаргаж ажиллах шаардлага тавьж ажиллаж байна.

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

ТЗБАХ-ээр хийгдсэн ажил:

110/35/10 кВ-н Даланзадгад дэд станцын 110 кВ-н Даланзадгад АШ-н ШинС, ШУС-н привод солих хоёрдогч хэлхээний холболт монтаж хийх ажлын хүрээнд 110 кВ-н Даланзадгад АШ-н ШУС, ШинС-н хуучин механик приводтой байсныг удирдлагатай приводоор сольж 110кВ-н шинС, ШУС-н привод руу кабель татаж холболт монтаж хийж хоригийн хэлхээг шалгаж хүчдэлд залгасан. Уг ажлыг РХАХТА-ны ажилтнууд болон засварын албаны ажилтнууд хийж гүйцэтгэсэн.



Зураг 1: Холболт монтаж хийсэн байдал



Зураг 2: Шинээр сольж тавьсан привод

Их засвараар хийгдсэн ажлууд:

110/35/10 кВ-н Даланзадгад дэд станцын 35 кВ-н СХТ, Хүрмэн, Жуулчин АШ-н реле хамгаалалтын панельд шинээр холболт монтаж хийв. 10 кВ-н бүх ячеюудын шаардлага хангахгүй кабелийг сольж, холболт монтажийг цэгцэлсэн.



Зураг 3,4: Ячеюудын монтаж цэгцэлсэн байдал

ЦДҮС ТӨХК болон Клин Энержи Ази ХХК-тай байгуулсан ашиглалт засварын гэрээний дагуу 147:148-р агаарын шугам, 110/35 кВ-н Цэций салхин цахилгаан станцад сар бүр ашиглалтын түвшин тогтоох үзлэгийг хийж ажилладаг. 147:148-р агаарын шугамд хийсэн үзлэгээр аянгын троссын дундын баригчийн бэхлэгээний ороолт буюу зөөлөвч тулгууртай үрэгдэж тасарсан, холгогдсон гэмтэл илэрсэн. Уг гэмтлийг 2023 оны 10 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд 4 механизм, 10 хүний бүрэлдэхүүнтэй засварын бригад хийж гүйцэтгэсэн.



Зураг 5: Аянгын тросс тасарсан хэсэг



Зураг 6: Гэмтэл устгасны дараах байдал

Тавантолгой, Даланзадгад дэд станцуудын өндөр үелзлэлийн холбооны автоматикийн блокийн хэрэглэгчийн холболтыг өөрчлөх гэмтэл устгах ажлыг 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс 06-ны өдрүүдэд хийж гүйцэтгэн холбоог хэвийн ажиллагаанд оруулсан.



Зураг 7: Гэмтэл устгаж байгаа ажлын явц

Салбарын Мандал, Тавантолгой, Оюутолгой, Цагаансуварга, Даланзадгад дэд станцуудад өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд ШУБ, ХХБ, ажилтнуудын амрах байрны хаалга цонх болон тоноглолын приводны хаалга кабелийн сувагт битүүмж сайжруулах ажил 2023 оны 10 дугаар сарын 16-аас 21-ний өдрүүдэд хийгдсэн.



220/22/35 кВ-н Цагаансуварга дэд станцад МАК ХХК-ийн уурхайн дарга Б.Мөнгөнжолоо, санхүүгийн мэргэжилтэн Т.Мөнхтөр, эрчим хүч хариуцсан ахлах мэргэжилтэн М.Жанболот, эрчим хүч хариуцсан мэргэжилтэн Б.Бямбасүрэн, дотоод аудитын мэргэжилтэн О.Гантулга, тус салбарын АШҮА-ны дарга Ч.Сугиртогтох, РХАХТА-ны дарга Б.Баярхүү, РХА-ийн монтер П.Лусван-Иш, АШҮА-ны ахлах бөгөөд диспетчер Б.Бүрэннэмэх нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2023 оны 10 дугаар сарын 13-16-ны өдрүүдэд Цагаансуварга дэд станцад ажилласан. Уг ажлын хэсэг улсын комиссоос өгсөн 42 үүрэг даалгавар болон ашиглалтын явцад илэрсэн 31 нэр төрлийн зөрчил дутагдлыг арилгах талаар газар дээр нь танилцаж дээрх зөрчил дутагдлыг хамтран арилгах зөвшилцөлд хүрсэн.

Цаг үеийн ажлаар:

Шинэ ажилтнуудад зориулсан сургалтыг туршилтын хугацаагаар томилогдсон 2 ажилтанд батлагдсан хөтөлбөрийн дагуу 2023 оны 09 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд салбарын инженер техникийн ажилтнууд зохион байгуулсан.

“Миний мэргэжил - Сайхан мэргэжил” сэдэвт мэргэжил сурталчлах өдөрлөг зохион байгууллаа.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор сургуулийн төгсөх 12-р ангийн сурагчдад мэргэжил сурталчлах өдөрлөгийг зохион байгуулав. Тус өдөрлөгөөр салбарын ерөнхий инженер Д.Цэрэндамба цахилгааны мэргэжлийн онцлог, давуу тал, үйлдвэрлэгчээс хэрэглэгч хүртэлх процесс, компани болон салбарын үйл ажиллагааны чиглэлийн талаар танилцуулга мэдээлэл хүргэж, зөвлөгөө өгөв. Мөн салбарын диспетчер инженер Б.Үүрийнтуяагийн удирдлага дор сурагчид Мандал дэд станцтай биечлэн танилцсан.



Зураг 9: Мандал дэд станцтай танилцсан сурагчид

“Угийн бичиг хөтлөх” тухай лекц зохион байгуулав.

Нийт ажилтнуудад зориулсан 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн нийтийн мэдээллийн цагаар Монгол өв уламжлалаа хадгалах, үр хойчдоо өвлүүлэх, зааж сургах зорилгоор “Угийн бичгийг хэрхэн хөтлөх тухай” сэдвээр МУ-ын гавьяат багш Ц.Цэвээнравдан багшаар лекц уншуулсан. Тус үйл ажиллагаанд нийт 32 ажилтан оролцсон. Ухаарал хайрлаж, ойлголт нэмсэн сайхан арга хэмжээ болсон.



Зураг 10: МУ-ын Гавьяат багш Ц.Цэвээнравдан багшийн лекц

Эерэг харилцаа, итгэлтэй ирээдүй лекц, Байгууллагын соёл сургалт зохион байгуулав.

Нийт ажилтнуудад зориулсан 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн нийтийн мэдээллийн цагаар “Эерэг харилцаа, итгэлтэй ирээдүй” лекц, “Байгууллагын соёл” сэдвээр сургалтыг харилцааны багш гэр бүл судлаач, докторант Х.Үүрийнтуяаг урьж зохион байгуулсан. Энэхүү лекцээр ажилтнууд болон түүний гэр бүлийн гишүүдийн хооронд үүссэн харилцаа ажлын байранд хэрхэн нөлөөлөх, гэр бүлтэйгээ эерэг харилцааг хэрхэн бий болгох талаар ажилтнуудад мэдлэг олгосон. Мөн “Байгууллагын соёл”-д хувь хүн хэрхэн нөлөөлөх, хэрхэн зөв төлөвшүүлэх, байгууллагын соёлд нөлөөлдөг муу шинжүүдийн талаарх ойлголтыг энгийн байдлаар ажилтнуудад хүргэсэн нь өгөөжтэй сургалт болсон. Тус лекц, сургалтад нийт 38 ажилтан хамрагдсан.



Мэдээллийг бэлтгэсэн: Захиргаа, аж ахуйн албаны албаны дарга Ц.Ганнягт

ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТНУУДЫН ЗӨВЛӨГӨӨН ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАРТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



Энэ оны 09 дүгээр сарын 25-наас 09 дүгээр сарын 29-ний өдрүүдэд Зүүн-Өмнөд бүсийн салбарт “Хүний нөөцийн ажилтнуудын зөвлөгөөн” болж өндөрлөлөө. Тус зөвлөгөөнд компанийн 5 салбар, төв удирдлагын нийт

20 гаруй ажилтан хамрагдсан бөгөөд уг зөвлөгөөнөөр, компанийн хүний нөөцийн үйл ажиллагаанд тулгамдаж байгаа асуудал, хүний нөөцийн хомсдолын эрсдэлийг бууруулах, тогтоон барих бодлогын хүрээнд ажилтнуудыг сургаж хөгжүүлэх, цалин хөлсний зохицуулалт,

нийгмийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх, Захиргаа, хүний нөөцийн ажилтнуудын ажлын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр сургалт явуулж, санал хэлэлцэж, туршлага солилцсон юм. “Хүний нөөцийн ажилтнуудын зөвлөгөөн” нь жил бүр зохион байгуулагддаг бөгөөд 2019


оноос цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж, хойшлогдоод байсан бол энэ жил Зүүн-Өмнөд бүсийн салбар, Говийн бүсийн салбар хамтран амжилттай зохион байгууллаа.

СУРГАЛТАД ХАМРАГДАВ

Энэ оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрүүдэд БНХАУ-н Ухань хотын “Sansion” үйлдвэрт “Өндөр хүчдэл ба гүйдлийн эталон трансформаторын шалгалт баталгаажилт, хэмжилт туршилт” сэдвээр РХАХТХ-н Цахилгаан хэмжлийн лабораторийн эрхлэгч Ж.Хосбаяр, Өндөр хүчдэл туршилтын инженер Б.Лут-Эрдэнэ, Хэмжүүр тоолуурын инженер Б.Золбоо, Хэмжүүрийн техникч Ц.Санжаабаатар, НРХА-н инженер Т.Ууганцэрэн нар сургалтанд хамрагдсан. Сургалтаар Ухань хотын “Sansion” үйлдвэрийн үйл ажиллагаа, өндөр хүчдэл, реле хамгаалалт, хэмжүүрийн тоног төхөөрөмжийн танилцуулга, үйлдвэрийн хэмжүүрийн трансформатор болон өндөр хүчдэлийн туршилтыг хийж гүйцэтгэсэн.



Мэдээллийг бэлтгэсэн: захиргаа удирдлагын хэлтсийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн Д.Энхбаяр



“ОЛОН УЛСЫН АХМАДЫН ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭВ

Төв удирдлага

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн захиргаа “Олон улсын ахмадын өдөр”-өөр ахмад ажилчдаа хүлээн авч хүндэтгэл үзүүлдэг уламжлалтай.

Төв удирдлагын ахмад ажилтнуудыг компанийн захиргаа 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдөр хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. Тус арга хэмжээний хүрээнд баярын хурал, хүндэтгэлийн цайллага зохион байгуулав. Ерөнхий инженер Б.Эрхэмзаяа баярын хурлыг нээн үг хэлж, гүйцэтгэх захирлын мэндчилгээг уламжилсан төдийгүй компанийн өнөөгийн нөхцөл байдлын талаар танилцуулав.



Баярын хурлын үйл ажиллганы төгсгөлд эрчим хүчний салбар болон компанид олон жил үр бүтээлтэй ажилласан ахмадууддаа шагнал гардуулж баяр хүргэсэн. Эрчим хүчний салбарын 100 жилийн ойн медиалиар нярав Г.Буяннэмэх, жолооч Д.Адъяажав, инженер Д.Одмаа, инженер Ч.Мөнхчулуун нарыг шагнасан бол хүрэлцэн ирсэн бүх ахмадууддаа компанийн 55 жилийн ойн гарын бэлэг гардуулав.

Мэдээллийг бэлтгэсэн: Захиргаа удирдлагын хэлтсийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн Д.Энхбаяр

Хангайн бүсийн салбар

Хангайн бүсийн салбарын хамт олон ахмад ажилчидаа 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Орхон аймагт “NOVA KOREAN” ресторанд, Өвөрхангай аймгийн Хархорин сумд Хорго-Арвижих төвийн ресторанд тус тус хүлээж авсан.



Уг арга хэмжээнд хүрэлцэн ирсэн ахмадууддаа салбарын дарга тэргүүтэй удирдлагын баг баярын мэндчилгээ дэвшүүлж, салбарынхаа 2023 онд хийж байгаа бүтээн байгуулалтын ажлаас товч танилцуулж, ахмадууддаа эрүүл энх, урт удаан наслахыг хүсэн ерөөв. Ахмадын баярын өдрийг тохиолдуулан салбарын даргын 2023 оны Б/182 дугаар тушаалаар нийт ахмадуудад хүндэтгэл үзүүлж хамтын гэрээний дагуу 6 120 000 (зургаан сая нэг зуун хорин мянга) төгрөгийн тэтгэмж, Эрчим хүчний болон бусад салбарын тэргүүний ажилтан 94 ахмадуудад 8 040 000 (найман сая дөчин мянга) төгрөгийн нэмэгдлийг тус тус олгосон.




Мөн салбарын даргын 2023 оны Б/183 дугаар тушаалаар 60, 70, 80, 85 насны ойг нь тохиолдуулан ахмад настан Ч.Мижиддорж, М.Дэлгэрсайхан, Д.Дашням, Д.Эрдэнэчимэг, Ц.Амгаланбаатар, Л.Даш, Ж.Магсаржав, Д.Доржтовуу, Д.Батдэмбэрэл, Т.Энхтуяа нарт баяр хүргэж, мөнгөн тэтгэмж гардууллаа.



Арга хэмжээний үеэр ахмад настан М.Баасанжав “Санхүү банкны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнагдсаныг Хархорин хэсгийн дарга гардуулж баяр хүргэлээ.

“Олон улсын ахмадын өдөр”-ийн арга хэмжээнд Засварын албаны засварын монтер М.Дэмиддагва, Хархорин хэсгий жолооч Д.Булган, ашиглалтын инженер Д.Төмөрдулам нар ая дууны мэндчилгээ дэвшүүлэв.

Мэдээллийг бэлтгэсэн: ЗАА-н албаны дарга Д.Цогбаяр



Улаанбаатар салбар

Улаанбаатар салбарын ахмадын хорооноос Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан салбарын ахмадуудаа Монголын Үйлдвэрчний Эвлэлийн “Сонгино” амралтад 2023.10.06-нд хүлээн авсан.

Тус баярын үйл ажиллагаанд нийт 63 ахмад хамрагдсан бөгөөд салбарын дарга Д.Будхүү тэргүүтэй удирдлагууд оролцлоо. Үйл ажиллагааны хүрээнд баярын хурал, бүжгийн тэмцээн болон азтан шалгаруулахаас гадна хамгийн өндөр настан Д.Сосорбарам, Х.Адъяа, Б.Хашаа нарт хүндэтгэл үзүүлээ. С.Болд, Т.Намсрай, М.Оюунжаргал, Б.Уртнасан, Д.Пүрэвсүрэн нар азын сугалааны эзэнээр тодорсон бол Д.Мөнхбаяр, Д.Бат-Өлзий, Д.Дагданпүрэв Л.Болормаа нар бүжгийн тэмцээнд тэргүүлэв.

Мөн ахмадын хорооноос 70-85 насны гэртээ асаргаанд өвчтэй байгаа 6 ахмадад гэрт нь очиж, хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардуулсан болно.



Хамгийн ахмад настан Д.Сосорбарам, Х.Адъяа, Б.Хашаа нарт хүндэтгэл үзүүлэх агшин



Хос бүжгийн тэмцээнд ахмадууд маань идэвхтэй оролцож тэргүүн байранд Д.Мөнхбаяр, Д.Бат-Өлзий нар шалгарсан бол, удаах байрыг Д.Дагданпүрэв Л.Болормаа нар эзлэв.



Ахмад Ш.Хандсүрэн Туул д/ст-д тасралтгүй 22 жил ажиллаж байсан туршлагатай сайхан буурай билээ.



Мэдээллийг бэлтгэсэн: УБС-ын ахмадын хорооны дарга С.Оюунцэцэг

ЭМГЭНЭЛ

НАЙДАНГИЙН НАМХАЙ (1946-2023)



Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан Найдангийн Намхай 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр хүнд өвчний улмаас ертөнцийн мөнх бусыг үзүүлж, эрчим хүчний салбарт хүнд гарз тохиолоо.

Н.Намхай 1946 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Ховд аймгийн Булган сумын нутаг Минжит голын хөвөөнд төрсөн. Булган сумын арван жилийн дунд сургууль, Москва хотын Эрчим

хүчний дээд сургууль, Намын дээд сургуулийг тус тус төгсөж, цахилгааны инженер, нам улс төрийн дээд боловсрол эзэмшсэн.

Улаанбаатар хотын цахилгаан шугам сүлжээний газарт

аянга хамгаалалт, туршилтын инженер, реле хамгаалалт автоматикийн инженер, цех болон салбарын дарга, инженерийн албаны дарга, борлуулалт эрхэлсэн орлогч дарга, ерөнхий инженер, намын үүрийн нарийн бичгийн дарга, Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал, захирлын зөвлөхөөр тус тус ажиллаж, аймаг хотын намын хороонд үйлдвэр үйлчилгээ хариуцсан хэлтсийн эрхлэгчийн албан тушаалыг нэр төртэй хашиж эрчим хүчний салбарын бүтээн байгуулалтад гар бие оролцож явсан.

Монгол Улсын эрчим хүчний салбар 2001 онд зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үед Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК байгуулагдан анхны гүйцэтгэх захирлаар томилогдож 700 гаруй ажилчидтай хамт олныг удирдаж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг технологийн горимд шилжүүлэн жигдрүүлэх, найдвартай ажиллагааг хангаж ажилласан.

Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК-ийг ОХУ-ын Эрчим хүчний системтэй зэрэгцээ ажиллах техник эдийн засгийн ашигтай горим боловсруулан хэрэгжүүлж, цахилгаан эрчим хүчний импорт-экспортын гэрээг ОХУ-тай 2002 онд байгуулж байсан.

Аймаг, хот, дүүргийн Ардын хурлын депутат, иргэдийн

хурлын төлөөлөгчөөр удаа дараа сонгогдож, хөдөлмөрийг хөнгөвлөх 20 гаруй шинэ санал, санаачилга гарган нэвтрүүлж, нийслэл хотын цахилгаан хангамжийг дээшлүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн.

Найдангийн Намхайн олон жилийн нөр их хөдөлмөр амжилт бүтээл, зүтгэлийг төр, нийгмээс үнэлж, Эрчим хүчний тэргүүний ажилтан цол тэмдэг, Ардын хувьсгалын 70, 80 жилийн ойн медаль, Алтан гадас одон, Аж үйлдвэрийн гавьяат ажилтан цолоор тус тус шагнаж байсан.

Түүний авьяас билиг, мятаршгүй зүтгэл, шинийг санаачлагч, бүтээлч сэтгэлгээ, улс орны хөгжил, чадавхыг бий болгоход гаргасан хүчин чармайлт, хувь нэмэр, эелдэг даруу, ажилсаг, нөхөрсөг зан чанар нь бидний зүрх сэтгэлд үүрд мөнхрөн үлдэж, эрчим хүчний салбарт тодоос тод гэрэлтэж байх болно.

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ
ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК

“НЭГЭН ЖАРНЫ ТҮҮХ” БУЛАН

ТАЙЛБАР: Монгол Улсад цахилгаан дамжуулах сүлжээ үүсэж хөгжсөний нэгэн жарны түүхэн ой 4 жилийн дараа тохиох болно. Түүхийн үйл явцтай холбогдуулан Дамжуулах сүлжээ сонинд “НЭГЭН ЖАРНЫ ТҮҮХ” буланг Ахмадын хорооноос шинээр нээж техникийн дэвшил, түүнийг эзэмшигч хөдөлмөрийн хүмүүсийн тухай цувралаар нийтэлж байна. Бид өмнөх дугаартаа Хангайн бүсийн салбарын түүхэн замналыг нийтэлсэн бол энэ дугаартаа Зүүн-Өмнөд бүсийн салбарын он дарааллын товчооныг хүргэж байна.

ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАРЫН ОН ДАРААЛЛЫН ТОВЧООН (ЦУВРАЛ-4)

1973 ОН: 1960 оноос БНМАУ нь Зөвлөлт холбоот улс, Холбооны Бүгд найрамдах Чехословак улс, Бүгд найрамдах Ардчилсан Герман улс зэрэг социалист системийн орнуудтай хамтран Монгол орон даяар хайгуулын ажил эрчимтэй хийж эхэлснээр 1973 онд Багануурын нүүрсний нөөцийг олжээ. 599800000 (таван зуун ерөн есөн сая найман зуун мянга) тонн хүрэн нүүрсний арвин нөөцийг илрүүлсэн.

1978 ОН: БНМАУ, ЗХУ-ын засгийн газрын хоорондын хэлэлцээрийн дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын нутаг дэвсгэрт орших нүүрсний орд газрын түшиглэн баригдах Багануурын уурхайн цахилгаан хангамжийн асуудлыг шийдэхийн тулд Улаанбаатар-Багануурыг холбосон 220 кВ хоёр хэлхээ цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажлыг ЗХУ-ын Эрчим хүчний барилга угсралтын трест эхлүүлсэн.

1978 ОН: 1978 оны 11-р сард БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тогтоолоор Улаанбаатар ЦШСГ-ын харьяа Багануурын салбар байгуулагдаж, салбарын анхны даргаар н.Лхамжавыг, мастераар Б.Нансалыг томилсон. Тус салбарын анхны ажилтнаар ДЦС-3-аас Ц.Мягмаржав, Зүүн хараагаас техникч Б.Эрдэнэчимэг, Т.Мижид, Улаанбаатараас К.Баделхан, Т.Лхагважав, Б.Магсаржав, Н.Дуламсүрэн, Ж.Ган-Очир, Ш.Нямсүрэн, С.Баасанхүү нар томилогдон ирж ажиллаж байв.

1978 ОН: 12 дугаар сарын 16-ны өдөр 220/110/35 кВ Багануур дэд станцын угсралт тохируулга, реле хамгаалалтын ажлыг ашиглалт засварын мастер Б.Нансал, РХА-ийн инженер Д.Зоригт нар ЗХУ-ын мэргэжилтэнгүүдтэй хамтран гүйцэтгэсэн.

1978.12.22: 220/110/35 кВ Багануур дэд станцыг түр схемээр хүчдэлд залгаж, 110 кВ хүчдэлээр 110/6 кВ Төв дэд станцыг түр холбон Багануурын уурхайг цахилгаан эрчим хүчээр хангаж эхэлсэн.

1980.08.15: Улаанбаатар ЦШСГ-ын харьяа Багануурын салбар Багануур дүүрэгт төвлөрч, үйл ажиллагаагаа явуулж эхлэв. Салбарын даргаар Н.Дуламсүрэн томилогдсон байна.

1982.07.01: Улаанбаатар ЦШСГ-ын харьяа Багануурын салбарын даргаар Л.Ёндон томилогдов. Энэ үед салбар 26 ажилтантай байсан байна.

1982.11.20: 110/ кВ Уул дэд станц ашиглалтад орсон. Дэд станцын ээлжийн техникчээр Ц.Мягмаржав, Н.Баасанхүү, Б.Эрдэнэчимэг нар ажиллаж байсан.

1983.06.15: 110/6 кВ-н Төв дэд станц ашиглалтад орсон. Тус дэд станц нь 220/110/35 кВ-н Багануур дэд станцаас 5,7 км хоёр хэлхээт 110 кВ-н ЦДАШ-аар тэжээгддэг. ТДН-10000/110/У1 маркийн 10000 кВА-н чадалтай 2 трансформатор суурилагдсан бөгөөд 6 кВ-ын 17–н гаргалгаатай. Дэд станцын ээлжийн техникчээр Ц.Мягмаржав, Н.Баасанхүү, Б.Эрдэнэчимэг, С.Сүхбаатар, С.Базарсундуй нар ажиллаж байсан.

1984.09.25: Багануур, Чойр тосгонд байрлах Зөвлөлтийн цэргийн нисэхийн болон байлдааны ангиуд Багануурын нүүрсний орд Бор-Өндөр, Айрагийн жоншны ордыг түшиглэн байгуулагдсан уулын олборлох баяжуулах үйлдвэрүүдийг ТЭХС-д холбон цахилгаан эрчим хүчээр хангахаар 126 кВА суурилагдсан хүчин чадалтай 220/110/35 кВ Багануур дэд станцын барилга угсралтын ажлыг ЗХУ-ын эрчим хүчний барилга угсралтын трест бүрэн дууссан ба ДЦС-3-тай 220 кВ хоёр хэлхээ 205,206-р ЦДАШ-аар 1984 оны 09-р сарын 25-ны өдөр холбогдсон. 220/110/35 кВ Багануур дэд станцын ээлжийн инженерээр Т.Төмөрбаатар, М.Лхам, Г.Бямбаа, Г.Булжинсүрэн нар ажиллаж байсан.

1984.11.22: Монгол Улсын зүүн өмнөд районы уул уурхай эрчим хүчний төслийн хүрээнд Чойр дахь Зөвлөлтийн цэргийн тойрог, төмөр зам, говийн болон зүүн бүс нутгийг хангах бараа, өвс, нефть, Хар-Айраг, Бор-Өндөрийн хайлуур жоншны үйлдвэрүүдийг эрчим хүчээр хангах Багануур-Чойр 207-р ЦДАШ, 220/110/35 кВ Чойр дэд станцын барилга угсралтын ажил бүрэн дуусаж, хүчдэлд залгасан бөгөөд тухайн үед суурилагд хүчин чадлын хэмжээ 126 МВА байсан. Тус дэд станцын ээлжийн инженерээр Г.Ганболд, С.Батжаргал, Ж.Мөнхцэцэг, Г.Саранцэцэг нар ажиллаж байсан.

1984.11.26: БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1984 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 328 тоот тогтоолоор “БАГАНУУР ЦАХИЛГААН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗАР” нэртэйгээр байгуулагдсан. Тус газрын анхны даргаар Б.Батнасан, Ерөнхий инженерээр Л.Ёндон, ерөнхий нягтлан бодогчоор Г.Равдан нар томилогдон ажилласан бөгөөд энэ тогтоолоор Чойрын салбар байгуулагдаж, анхны даргаар нь Б.Хужаа томилогдон ажиллаж байв. Тэр үед Багануурын районы хуваарилах сүлжээг ашиглалтад авч, ашиглалт засвар, автограж гэсэн нэгжүүдтэй ажиллаж байсан.

1984.12.11: 110 кВ Чойр-Бор-Өндөрийн ЦДАШ, 110/35/6 кВ Бор-Өндөр дэд станц хүчдэлд залгагдсан. Тус дэд станц нь 32 МВА-н суурилагдсан хүчин чадалтай Бор-Өндөрийн Уулын Баяжуулах Үйлдвэр болон ойролцоох хот тосгоныг эрчим хүчээр хангах зорилгоор ашиглалтанд орсон. Дэд станцын анхны мастераар Л.Дамдинбазар, техникчээр Т.Цэенбямба, Н.Бямбасүрэн, Н.Бат-Өлзий, Х.Энхтуяа нар ажиллаж байсан.

1986.06.04: Улаанбаатар хотын Багануур дүүргийн айл өрх, аж ахуй нэгж байгууллагыг цахилгаан эрчим хүчээр хангах 110/6 кВ-н

Хот дэд станцыг хүчдэлд залгагдсан. Тус дэд станц нь 220/110/35 кВ-н Багануур дэд станцаас 0.8 км хоёр хэлхээт 110 кВ-н ЦДАШ-аар холбогдсон. ТДН-16000/110/У1 маркийн 16000 кВА-н чадалтай 2 трансформатор суурилагдсан. Дэд станцын ээлжийн техникчээр Ц.Мягмаржав, Н.Баасанхүү нар ажиллаж байсан.

1986.11.21: Дорноговь аймгийн айл өрх, аж ахуйн нэгжийг цахилгаан эрчим хүчээр хангах 110 кВ Чойр-Айраг ЦДАШ, 110/35/10 кВ Айраг дэд станцыг хүчдэлд залгасан. Дэд станцын анхны мастераар Э.Оюунцэцэг, техникчээр Н.Баатархуяг, Д.Нэргүй, Ц.Бямбатогтох нар ажиллаж байсан.

1987.04.30: Багануур ЗӨБЦШСГ-ын ерөнхий инженерээр Д.Амгаланбаатар томилогдсон.

1987 ОН: 110 кВ Төв-Галуутын 2 хэлхээ ЦДАШ, дэд станцын барилга, угсралтын ажил дуусаж, хүлээн авч, хүчдэлд залгасан.

1990.07.20: 110 кВ Айраг-Сайншанд ЦДАШ, 110/35/10 кВ Сайншанд дэд станцыг хүчдэлд залгасан. Дэд станцын анхны мастераар н.Авирмэд, техникчээр У.Долгорсүрэн. Г.Цэцгээ нар ажиллаж байсан.

1990.07.20: 110 кВ Бор-Өндөр-Баянмөнх ЦДАШ, 110/10 кВ Баянмөнх дэд станцыг хүчдэлд залгасан. Тус дэд станцад ээлжийн техникчээр Б.Эрдэнэчимэг, монтёроор Ж.Алтангэрэл нар ажиллаж байсан.

1993.09.15: Багануур ЗӨБЦШСГ-ын даргаар Ж.Шагдарсүрэн томилогдсон, ерөнхий инженерээр Д.Амгаланбаатар ажиллаж байсан.

1996.04.19: Говийн бүсийг ТЭХС-тэй холбох 220 кВ Чойр-Мандалговийн ЦДАШ, 110/35/10 кВ Мандалговь дэд станцыг хүчдэлд залгасан. Дэд станцын анхны техникчээр Б.Цэрэндорж, И.Оюунцэцэг, Ж.Батбилэг, Д.Будаев нар ажиллаж байсан.

1997.01.08: 110 кВ Баянмөнх-Өндөрхааны ЦДАШ, 110/35/6 кВ Өндөрхаан дэд станцыг хүчдэлд залгаж, зүүн аймгийн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах нөхцөл бүрдсэн. Дэд станцын ээлжийн техникчээр Р.Ганбат, Т.Баярхүү, Д.Чимиддондов, Х.Одсайхан нар ажиллаж байсан.

2001.08.01: 2001 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 164 дүгээр тогтоолоор эрчим хүчний салбарын төрийн өмчит үйлдвэрийн газруудад бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийж 110 кВ-с дээш хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, түүний дэд станцуудыг хариуцсан Төвийн Бүсийн Цахилгаан Дамжуулах Сүлжээ ТӨХК байгуулагдаж Багануур, Хэнтий, Чойр, Дундговь, Дорноговь аймгуудын нутаг дэвсгэрүүдэд байгаа 220/110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын найдвартай ажиллагааг хариуцах “Багануур-Чойрын салбар” байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Салбарын анхны даргаар Ц.Бямбатогтох, ерөнхий инженерээр Д.Амгаланбаатар, ахлах нягтлан бодогчоор Ж.Гэрэлмаа, Чойр хэсгийн ахлах инженерээр Б.Туяа нар томилогдон ажилласан.

2003.07.25: 110 кВ Сайншанд-Замын-Үүд ЦДАШ, 110/10 кВ Замын-Үүд дэд станцыг хүчдэлд залгаж, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын айл өрх, аж ахуй нэгжийг төвийн эрчим хүчний системээс эрчим хүчээр хангаж эхэлсэн. Тус дэд станц нь 10 МВА суурилагдсан хүчин чадалтай, салбарын анхны микропроцессорны хамгаалалт бүхий дэд станц юм. Дэд станцын анхны техникчээр Г.Баттулга, Ч.Оюунтүлхүүр нар ажиллаж байсан.

2003.04.11: 220/110/35/6 кВ Чойр дэд станцын 110 кВ талаас Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг цахилгаан эрчим хүчээр хангах 110 кВ Шивээ-Овоо ЦДАШ, дэд станцыг хүчдэлд залгасан. Тус дэд станцад ээлжийн техникчээр Б.Энхням, монтёроор Д.Бямба нар томилогдон ажиллаж байсан.

2003 оны 06-р сар: Засварын инженер Н.Баатархуяг, зураг, төсвийн инженер Б.Түвшинбаяр нарын санаачилгаар 5 аймгийн нутаг дэвсгэрт ажиллаж байгаа хамт олондоо салбарын ажлыг цаг хугацаанд хүргэх,тэргүүний ажилтнуудаа сурталчлах, орон нутгийн мэдээллийг түгээх зорилгоор “Тулгуур” сонинг эрхлэн гаргаж эхэлсэн.

2003.06.12-06.14: ТБЦДС ТӨХК-ийн Инженер техникийн ажилтнуудын анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулав. Зөвлөгөөнд компанийн салбар бүрээс төлөөлөгч ирж, 40 ажилтан оролцож, салбарын техникийн бичиг баримтын бүрдүүлэлт, анхан шатны бүртгэл, бүтээлч ажил, цахилгаан дамжуулах агаарын шугамын ашиглалтын карт, технологийн карт зэргийг танилцуулж, үзүүлэх сургууль хийсэн.

2006.11.05: Ерөнхий инженер Д.Амгаланбаатараар ахлуулсан ашиглалтын инженер Б.Пүрэвсүрэн, засварын инженер Н.Баатархуяг, засварын мастер Д.Лувсанжамц, ХХАА сургалтын инженер Г.Наранцэцэг, РХА-ын инженер Ж.Чинбат, ерөнхий диспетчер Д.Анхбаяр, диспетчер инженер Ш.Жаргалтогтох Б.Түмэнбаяр диспетчер техникч Э.Бүрэнжаргал, жолооч З.Манлай нар Дархан-Сэлэнгэ, Эрдэнэт-Хархорины салбарын дэд станцуудын үйл ажиллагаа, ИТА-тай танилцан туршлага санаачилгыг ажилдаа хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллав.

2006.12-р сар: Эрчим хүчний үйлдвэр компанийн шуурхай ажиллагааны ажилтнуудын дунд зохион байгуулсан

ажил мэргэжлийн тэмцээнд Г.Туяа ахлагчтай “Тулгуур” баг 2-р байр эзлэв.

2007 он: Компанийн 40 жилийн ойг угтсан арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан “Мэдлэг-Чадвар” ажил мэргэжлийн тэмцээнд Ж.Чинбат ахлагчтай баг 2-р байр эзлэв.

2009 оны 09-р сар: Шведийн олон улсын хөгжлийн агентлаг SIDA төслийн хүрээнд Бор-Өндөр дэд станцын 110 кВ ИХБ-д Т-1, Т-2 110 кВ ОД, КЗ-ыг хурааж “LTB-170D1/B” загварын элэгз таслуурыг угсрах засварын инженер Н.Баатархуягийн удирдлагаар Чойр хэсгийн ажилтнууд угсарч ажиллагаанд залгасан.

2009 оны 10-р сар: Шведийн олон улсын хөгжлийн агентлаг SIDA төслийн хүрээнд Чойр дэд станцын АТ-1, 2-ын 220 кВ ОД, КЗ-г хураан “HFL245-B1” маркийн элэгз таслуурыг засварын инженер Н.Баатархуягийн удирдлагаар Чойр хэсгийн ажилтнууд угсарч ажиллагаанд залгасан.

2009 оны 10-р сар: Шведийн олон улсын хөгжлийн агентлаг SIDA төслийн хүрээнд 220/110/35 кВ Багануур дэд станцад Скада болон эрчим 1 багц хөтөлбөр хэрэгжиж диспетчерийн шуурхай ажиллагааг Диспетчерийн үндэсний төв төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болон компанийн төв диспетчерээс хянадаг болсон байна.

2011 оны 05-р сар: Компанийн хэмжээнд зохион байгуулагдсан урлагийн анхдугаар их наадамд тэргүүн байр эзлэв.

2011 оны 08-р сар: 220/110/356 кВ Чойр дэд станцын 110 кВ I, II систем шин, тойруу систем шинийг “Восток энерго монтаж” ХХК өргөтгөсөн.

2011 ОН: Салбарын дарга Ц.Бямбатогтохын удирдлага дор салбарын ажилтнууд 110 кВ Чойр-Төмөрт ЦДАШ-ын барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн./ Дундговь аймгийн Говь-Угтаал сумын нутагт орших цайрт төмөрлөгийн цахилгаан хангамжийн асуудлыг шийдсэн./

2012 оны 01-р сар: Салбарын даргаар Д.Ганзориг, ерөнхий инженерээр Д.Нямсүрэн, нар томилогдон ажилласан.

2012 оны 06-р сарын 20: Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 108 дугаар тогтоол, хувь нийлүүлэгчдийн хурлын 2012 оны 05, 07 дугаар тогтоол, “компанийн бүтцийг шинэчлэн батлах тухай” төлөөлөн удирдах зөвлөлийн 2012 оны 20 дугаар тогтоолоор компанийн болон салбарын нэр, бүтэц, орон тоо өөрчлөгдөж, Төвийн Бүсийн Цахилгаан Дамжуулах Сүлжээ ТӨХК-ийг Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ ТӨХК, тус салбарыг Зүүн-Өмнөд бүсийн салбар нэртэй болгон өөрчилсөн.

2012 оны 05.01- 09.15: 110/10 кВ Сургалт дэд станц болон сургалтын танхимыг өөрсдийн хүчээр барьж байгуулан, ашиглалтад оруулсан. Сургалтын төвийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь эрчим хүчний салбарт ажиллаж байгаа ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах, шинэ залуу хүмүүсийг мэргэжилтэй болгоход чиглэсэн.

2012 оны 12-р сар: Зөвлөх инженер Д.Амгаланбаатарын удирдлаган дор салбарын инженер техникийн ажилтнууд өөрсдийн хүчээр Мон полимент ХХК-ийн Өргөний цементийн үйлдвэрийг хангах 53 км урт Сайншанд-Булагтын 110 кВ ЦДАШ, дэд станцын барилга, угсралтын ажлыг гүйцэтгэсэн байна.

2012 оны 12-р сар: Салбарын даргаар Д.Нямсүрэн, ерөнхий инженерээр Б.Пүрэвсүрэн нар томилогдон ажилласан.

2013.01.29: “MCS” группийн төслөөр баригдсан SFSZ-16000/115 трансформатор бүхий 32000 кВА суурилагдсан хүчин чадал бүхий Тавантолгой дэд станцыг хүчдэлд залгаж хүлээн авч Мандалговь-Тавантолгой 220 кВ ЦДАШ-аар 110 кВ хүчдэл өгч Тавантолгой дэд станцаас Даланзадгад 110 кВ ЦДАШ-д 35 кВ хүчдэл өгч Өмнөговь аймгийн төв, Манлай сумдыг төвлөрсөн эрчим хүчний системд холбосон.

2013 оны 04 сар:110/35/10 кВ Тавантолгой дэд станцын ашиглалтыг хүлээн авч, ахлах диспетчер техникчээр З.Бат-Эрдэнэ, техникчээр Г.Содномцэрэн, Д.Ягаанцэцэг,Д.Эрдэнэчимэг, Б.Мянганбуу, монтёроор П.Бямба, Л.Цолмонбаяр, Д.Гэрэлчулуун, Д.Дэлгэрмаа нарыг томилон ажиллуулав.

2013 ОН:НХХЯ-наас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулах улсын уралдааны жижиг аж ахуйн нэгжийн ангилалд Чойр хэсгийн хамт олон улсад тэргүүн байр эзлэж, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан.

2014 ОН: ЦДЭС ТӨХК-ийн УЭХ-ны нэрэмжит спортын 5 төрөлт тэмцээнийг амжилттай зохион байгуулж, шилжин явах цомыг салбартаа үүрд үлдээсэн.

2014 ОН: НХХЯ-наас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулах улсын уралдааны дунд аж ахуйн нэгжийн ангилалд салбарын хамт олон улсад 4-р байр байр эзлэж, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан.

Үргэлжлэлийг дараагийн дугаарт

Эрхлэн гаргасан: Захиргаа удирдлагын хэлтсийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн Д.Энхбаяр